

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Мягмар гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-5

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 6-43

---

*1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/* 6-43

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
11 дүгээр сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Батсүмбэрэл, А.Ундраа;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга, Б.Жаргалан, О.Цогтгэрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд үг хэлэв.

**Нэг.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хуулийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ, “Мон-Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Г.Жамсрандорж, Я.Ганболд, Л.Жаргалсайхан, Д.Баярхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл, заалт бүрээр хэлэлцэв.

## **Нэг.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Р.Сэддорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8.1.4 дэх заалтын “шийдвэрлэх” гэсний дараа “Засгийн газраас цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг шинээр олгох, бусдад шилжүүлэх асуудлаар зөвшөөрөл авахаар өргөн мэдүүлснийг хэлэлцэж, хариуг өгөх гэж нэмэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 11

Бүгд: 16

31.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 9.1.10 дахь заалтын “тогтоох” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Улсын Их Хурлын зөвшөөрлөөр эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 10

Бүгд: 16

37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уул уурхайн үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийн баталгааг энэ хуулийн 34.6-д заасан шаардлагад нийцсэн банкны баталгааг гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 9

Бүгд: 16

43.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, М.Бадамсүрэн, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс

баялгийн сайд Ц.Туваан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Мон-Атом” ХХК-ийн мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн, О.Батнайрамдал нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, “Мон-Атом” ХХК-ийн Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, мөн компанийн Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр нар хариулж, тайлбар хийв.

*Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Р.Сэддорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 5.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.4.Энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас илүү хувиар төр хувьцаа эзэмших тохиолдолд стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж үг хэлэв.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 5  |
| Татгалзсан: | 13 |
| Бүгд:       | 18 |

27.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 5.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.4.Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ зүйлийн 5.2, 5.3-т заасан хувь хэмжээг Засгийн газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох бөгөөд Засгийн газар тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдааны тогтоолоор хэлэлцэн шийдвэрлэсэн талаарх танилцуулгыг жил бүр Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 7  |
| Татгалзсан: | 11 |
| Бүгд:       | 18 |

38.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 5.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.4.Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад өнөөгийн үнэ цэнээр эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ хуулийн 5.2, 5.3-т заасан хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 5  
Бүгд: 18  
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэнгийн тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Мон-Атом” ХХК-ийн мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр нар хариулж, тайлбар хийв.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

#### **Хоёр.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

#### **Гурав.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон нар хариулж, тайлбар хийв.

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Хуульд” гэсний өмнө “Цөмийн энергийн тухай” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 8  
Бүгд: 19  
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 36 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 41 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим  
10 цаг 05 минут.

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдааны ирц 56 хувьтай байна. Ирсэн гишүүд Сэддорж, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батчимэг, Батушугар, Ганбаатар, Ж.Ганбаатар, Ганхуяг, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Энхтүвшин гишүүд хүрэлцэн ирсэн байна. Батсүмбэрэл гишүүн гадаад томилолттой. Тэгэхдээ одоо ирж байгаа юм шиг байна, томилолтын хугацаа дуусаагүй ч гэсэн. Ундраа гишүүн гадаад томилолттой байна. Бусад хүмүүс бол шалтгаангүй байгаа юм байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Ирцийг танилцуулж дууслаа.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, ЗГ-аас 2024 оны 10 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Соронзонболд гишүүн микрофон нээе.

**Л.Соронзонболд:** Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Ер нь нөгөө Эдийн засгийн байнгын хороон дээр бид нар бас ер нь 2 сар гаруй хугацаанд бас тодорхой хэмжээнд хурлууд хийлээ. Гишүүд зөв зүйтэй асуулт асууж, саналууд гаргасан. Тэгэхээр тэр гаргасан саналууд дээр нөгөө тухайн үед асуудал танилцуулж байсан яам, агентлагууд нь яг ямар ажлууд хийж байгаа талаар нэг тайланг бас нэг тодорхой хугацаатай сонсдог байхгүй бол зүгээр ингээд асуугаад, саналаа хэлээд тэгээд л ингээд орхидог байдалтай байж болохгүй болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр энэ тал дээр Эдийн засгийн байнгын хорооноос тэр тухайн асуудал танилцуулж байсан яам, агентлагуудад нь даалгавар өгвөл яасан юм бэ гэсэн нэг ийм санал байна.

**Р.Сэддорж:** Санал нэг байна. Энэ дээр яригдсан зүйлүүд бол ажлын алба маш сайн энийг хянамгай яаж энэ яамнуудаас хариулт юуг нь авч бэлэн болгох хэрэгтэй. Тэгээд энэ асуудлыг Байнгын хорооноос мэдээлэл сонсох гээд оруулчих уу. Тэгээд түүн дээр ярьчихъя, тийм тэгье. Өөр хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай хүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудал дээр өөр асуулт, санал байхгүй байна. Сая Соронзонболд гишүүний саналыг нэмлээ. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг танилцуулъя.

Ажлын хэсэг Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Бат-Эрдэнийн Хулан ЗГХЭГ-ын зөвлөх, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж

үйлдвэр, эрдэс баялгийн яамны *Техник технологийн хэлтсийн дарга*, *Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга*, *Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга*, *Зэнээмядарийн Батбаяр Усны газрын дарга*, *Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга*, *Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын Цөмийн технологийн бодлогын газрын дарга*, *Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга*, *Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал*, *Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн*, *Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга*. *Босоод танилцуулчхаж байгаа юу гишүүдэд? Доржбалын Далайжаргал Мон-Атом компанийн гүйцэтгэх захирал*, *Амарсайханы Алтанхундага Мон-Атом компанийн Геологи, уул уурхайн албаны ахлах инженер*, *Даидаваагийн Сугарсүрэн Мон-Атом компанийн Захиргааны удирдлагын албаны дарга*, *Норовын Тэгшбаяр Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч*, *физикийн ухааны доктор*, *Галсандоржийн Жамсрандорж Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч*, *геологи эрдэс судлалын ухааны доктор*, *Яндагийн Ганболд Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч*, *Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх*, *Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн*, *академич*, *профессор*, *Лхасүрэнгийн Жаргалсайхан Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч*, *Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал доктор*. *Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.*

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төсөл 5 зүйлтэй, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарна.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. 1 дүгээр зүйл. Мөнхсоёл гишүүнээр, Бадамсүрэн гишүүн. Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

**М.Бадамсүрэн:** 2 дээр асууя.

**Р.Сэддорж:** Бадамсүрэн гишүүн 2 дугаар зүйл дээр асуулт. Гишүүд 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж дууслаа, хариулт авч дууслаа. Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдийн ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Бадамсүрэн гишүүнээс 2 санал орж ирсэн.

Төслийн, би эхлээд уншаадахъя. Та тайлбарлачих. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8.1.4 дэх заалтын “шийдвэрлэх” гэсний дараа “Засгийн газраас цацраг идэвхт ашигт малтмал эрэх хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг шинээр олгох, бусдад шилжүүлэх асуудлаар зөвшөөрөл авахаар өргөн мэдүүлснийг хэлэлцэж, хариуг өгөх гэж нэмэх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 1 дүгээр асуудал дээр, нэг нэгээр нь явъя. Тайлбар Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.



**М.Бадамсүрэн:** Цацраг идэвхт ашигт малтмалыг Цөмийн энергийн тухай хуульд 6.1-д зааснаар цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ангилалд хамааруулна гэж заасан байгаа. Тэгэхээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал гэдгийг Ашигт малтмалын тухай хуульд заахдаа үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц болон улс орны эдийн засаг, нийгмийн асуудалд нөлөөлөхүйц хэмжээний ийм ордыг стратегийн ордод хамааруулна гэж заасан байгаа. Тэгэхээр цаашидаа бол стратегийн ордыг тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх асуудлыг бол ЗГ өөрийнхөө эрх хэмжээнд авах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Түүгээр үл барам цацраг идэвхт ашигт малтмал, газрын тос, стратегийн ордуудыг шинээр олгох, бусдад шилжүүлэхдээ Улсын Их Хуралд танилцуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр ЗГ шилжүүлье. Өөрөөр хэлбэл Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтэс гэдэг 1 албан тушаалтан гарын үсгээрээ энэ том ордыг олгодог байх нь зохимжгүй гэж үзэж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар байгалийн баялаг бол төрийн нийтийн өмч гэж байгаа юм. Тэгээд төрийн нийтийн өмчийг буюу ард түмний өмчийг ард иргэдийг төлөөлж захиран зарцуулах энэ эрх нь бол Улсын Их Хуралд байдаг. Тухайлбал та бүхэн мэдэж байгаа. Төрийн өмчийг бусдад шилжүүлэх, шинээр олж авах асуудлыг гагцхүү Улсын Их Хурал шийддэг.

ЗГ-ын эрх дээр бол тодорхой байгаа. Тухайлбал ЗГ бол өндөр т...тэй барилгын зөвшөөрлийг олгодог, согтууруулах ундааг импортоор оруулж ирэх зөвшөөрөл, согтууруулах ундааг үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүртэл олгодог шүү дээ. Гэтэл энэ хөрс доорх байгалийн баялаг тэр дундаа цацраг идэвхт уран гэдэг бол өөрөө асар том асуудалтай. Манай та бүхэн мэдэж

байгаа. Зарим стратегийн ордууд, зарим энэ стратегийн шинж чанартай ордуудыг зарим орны хөрөнгө оруулалттай компаниудад эзэмшүүлдэг, лиценз олгодог. Энэ нь явцын дунд буцаад өөр гадаадын хөрөнгө оруулалттай эсвэл өөр ААН-д шилжүүлдэг. Энийг тухайн үед бол Ашигт малтмалын газрын эсвэл зарим тохиолдолд ЗГ-ын зөвшөөрлөөр шилжүүлдэг ийм тохиолдлууд байгаа. Гэхдээ энэ нь асар том маргаан дагуулсан гэдгийг өнгөрсөн хугацаанд бид бүхэн мэдэж байгаа. Тухайлбал газрын тосны асуудал байна. Сүүлд энэ ураны асуудлууд ингээд бас гарч ирнэ.

Тийм учраас энэ зүйл дээр Улсын Их Хурал ард түмний өмнөөс мандат эдэлж байгаа бол энэ Үндсэн хуульд заасан төрийн нийтийн өмчийн зарцуулах, ард түмнийг төлөөлөх энэ үүргээ биелүүлж, энэ дээр нь зөвшөөрөл өгдөг байх нь зүйтэй гэж үзэж байгаа. Магадгүй нөгөө талдаа Улсын Их Хурал бүх юманд оролцох гээд байна гэдэг асуудал ярьж магадгүй. Тэгвэл энэ тийм биш. Яагаад гэвэл стратегийн орд, цацраг идэвхт ашигт малтмал зэрэг, газрын тос зэрэг зүйл дээр л оролцдог байя. Бусад жонши, нүүрс, зэс, алт гээд энэ зүйл дээр нь ердийн журмаараа явдаг байхад бол болно гэж үзэж байгаа. Тэгээд тийм учраас Улсын Их Хурлын гишүүд та бүхэн маань энэ маш чухал цаг үед цөмийн энергийн тухай асуудлаар бас шийдвэр гаргах гэж байгаа учраас энэ зүйл дээр хожмын үр дагаврыг тооцож, асар болгоомжтой хандаж, хожим хойч үедээ хэлэх үгтэй, гарсан шийдвэр нь оновчтой байхад энэ зохицуулалт бол гарцаагүй чухал байгаа юм гэдгийг Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ танилцуулж байна. Тэгээд та бүхэн маань энэ утгаар нь, энэ агуулгаар нь энэ саналыг бас дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Аюулгүй байдлын байнгын хороон дээр, чуулганы хуралдаан дээр гишүүд энэ үгээ хэлэх юм байна. Одоо дэгээр бол тайлбар бол авахгүй юм

байна. Шууд санал хураалт юм байна. Түрүүнд асуулт асуух, хариулт авах гишүүд гээд байсан. Дараагийн 2 дахь зүйл дээр бол та бүхэн маань бас энэ зүйлүүдээ ярихад нээлттэй байх нь. Ингээд, шууд энүүгээр биз дээ? Бадамсүрэн гишүүний гаргасан саналаар Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8.1.4 дэх заалтын “шийдвэрлэх” гэсний дараа “Засгийн газраас цацраг идэвхт ашигт малтмал эрэн хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг шинээр олгох, бусдад шилжүүлэх асуудлаар зөвшөөрөл авахаар өргөн мэдүүлснийг хэлэлцэж, хариуг өгөх гэж нэмэх.” гэсэн саналаар Бадамсүрэн гишүүний гаргасан саналаар санал хураалт. 31,3 хувиар санал дэмжигдсэнгүй.

2 дахь санал 2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 9.1.10 дахь заалтын “тогтоох” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмал эрэн хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох Улсын Их Хурлын зөвшөөрлөөр эрэх хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн. Тайлбар Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

**М.Бадамсүрэн:** Энэ Зөвшөөрлийн тухай хуультай нийцэх эсэхийг бол сайн мэдэхгүй байна. Энэ бол яаралтай горимоор ЗГ-ын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэж байгаа Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдгийг л Улсын Их Хурлын гишүүд ойлгох хэрэгтэй. Ер нь бол энэ Цөмийн энергийн хууль шинэчлэгдсэнээр, гэрээ байгуулагдсанаар тэгээд нийгэмд болон байгаль орчинд асар их олон үйл явдал өрнөнө шүү. Тийм учраас Их Хурлын гишүүд энэ дээр бас алсыг харж, бодолтой байгаасай л гэж хүсэж байна. Зөвхөн Зөвшөөрлийн тухай хууль гэдгээсээ гадна энэ бол яаралтай горимоор хэлэлцэгдэж байгаа улс орны үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжилд онцгой нөлөө

үзүүлэхүйц ийм ордыг стратегийн орд гэнэ гэж хуульд заасан.

Энэ үүднээсээ нөгөө талаасаа Цөмийн энергийн тухай хуулийн 6.1-д энэ цацрагт идэвхт ашигт малтмал бол хэмжээнээс үл хамаараад стратегийн ордод орно л гэж заасан байгаа. Тийм учраас бусад жонш, нүүрс зэрэг ашигт малтмалтай адилгүй, арай өөр горимоор энийг Улсын Их Хурал, ЗГ өөрөө шийддэг байх. Гэхдээ Улсын Их Хуралд танилцуулж, зөвшөөрөл авдаг байх. Өөрөөр хэлбэл Ашигт малтмал, газрын тосны газар гэдэг нэг агентлаг түүний доторх хэлтсийн дарга шийддэг байхгүй л гэдэг ийм л санааг агуулж байгаа юм. Агуулгын хувьд бол та бүхэн бас ингэж энэ талаас нь ойлгоорой. Энэ бол бидний хувьд бол ЗГ өөрөө энэ асуудлаа хариуцлагаа хүлээдэг, ЗГ өөрөө олгодог, өөрөө шилжүүлдэг байх. Тэгээд би түрүүн хэлсэн ЗГ бол өндөр т...тэй барилгын зөвшөөрлийг өгдөг, импортоор согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүртэл олгодог.

Тэгэхээр энэ байтугай энгийн харилцааг ЗГ өөрөө зохицуулдаг шүү дээ. Тэгэхэд энэ бол уран шүү дээ, Цөмийн энергийн тухай хуулиар зохицуулж байгаа цацраг идэвхт ашигт малтмал. Тэгэхээр энэний үр дагаврыг бол та бүхэн мэдэж байгаа учраас ингэж томъёолж оруулсан юм. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье.

**Р.Сэддорж:** Энэ 10 сарын 25-нд хуулийн төслүүд гишүүдийн гар дээр очсон. Бадамсүрэн гишүүний гаргасан саналаар Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 9.1.10 дахь заалтын “тогтоох” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмал эрэн хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох Улсын Их Хурлын зөвшөөрлөөр эрэх хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Санал хураалт. 37,5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал, энэ болчихсон уу? 34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уул уурхайн үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар, арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийн баталгааг энэ хуулийн 34.6-д заасан шаардлагад нийцсэн банкны баталгааг гаргана. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин. Саналаа тайлбарлая, Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

**Д.Энхтүвшин:** Энэ нөгөө хэлэлцүүлгийн хэлэлцэх эсэх дээр бас яригдаж байсан асуудал. Нөгөө мөнгөн хөрөнгөөр байриуулна гэхихсэн байсан. Тэгэхээр энэ нь өөрөө төслийн зардалд бас нэлээн өндрөөр нөлөөлж магадгүй учраас зайлиггүй буцаад бид нар энэ байриуулж байгаа мөнгөн хөрөнгөө бусад өөр эргэлтэд оруулах бололцоогүй учраас төслийн зардлыг бас нэмэгдүүлэх эрсдэл байгаа учраас энэ заавал мөнгөн хөрөнгө байриуулах биш, энэ өөр төлбөрийн хэрэгсэл, бололцоо, боломжууд байгаа юм чинь шаардлагыг нь тавиад, ЗГ-аас ямар хэмжээний банкны баталгааг ямар хэмжээтэй байх юм гэдгийг нь зааж өгөөд, энэ банкны баталгаагаар тавьдаг болгоё гэсэн ийм санал байгаа.

Тэгэхээр 34.5-д нь болохоор энэ банкны юутай холбоотой уул уурхайн үйлдвэрийн хаалт болон нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар, арчилгаанд зарцуулах энэ мөнгөн хөрөнгийнхөө баталгааг банкны баталгаагаар гаргана гэдгийг нь энэ 34.6-д нь дараа нь бас хураалгах санал дээр болохоор энэ хуулийн 34.5-д заасан банкны баталгааны шаардлагыг ЗГ тогтооно гээд. Тэгэхээр ямар зэрэглэлийн, ямар банк байх юм гэдэг шаардлагыг нь тавьчихвал төслийн зардлыг бууруулахад нэмэртэй юм уу гэсэн тэгэхээр ийм санал гаргаж байгаа. Тэгээд гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

**Р.Сэддорж:** Тэгээд энэ саналаа тайлбарлаж байгаа гишүүнээс санал асууж болохгүй юм уу? Дахиад уншъя. Та хэд сайн уншиж байж санал өгөхгүй бол болохгүй нь байна шүү. 34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уул уурхайн үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар, арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийн баталгааг энэ хуулийн 34.6-д заасан шаардлагад нийцсэн банкны баталгааг гаргана. гэж байна. Ажлын хэсгээс төслөө тайлбарлая. 4 Номерын микрофон, хэн тайлбарлах юм бэ, 5 номерын микрофон. 3 номер дээр очоод суучих, 3 номерын микрофон нээе.

**Г.Намчинсүрэн:** Энхтүвшин гишүүний гаргасан санал дээр нэмэлт тайлбар өгье. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн Техник технологийн хэлтсийн дарга. Энэ уг нь бол хөрөнгө оруулагч тал төсөл, тусгай зөвшөөрөл эзэмшигч маань банкны баталгаа гэхээсээ илүүтэй үйл ажиллагааны зардлаасаа жил бүр тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг хуримтлуулаад явъя гэсэн санал гаргаж байгаа юм. Тэгээд энэ дээр хөрөнгө оруулалтын хэлэлцээр болон техник, орд ашиглах ТЭЗҮ дээр энэ асуудлууд нь тусгагдаад явж байгаа. Яг баталгаа гэдэг ойлголт нь бол өөр асуудал болчхож байгаа юм.

Өөрөөр хэлбэл олон улсад бол баталгаа гаргадаг, мөнгөн хөрөнгө байриуулдаг. Тэрийгээ ямаршуу байдлаар аль банкны ч юм уу, олон улсын ч юм уу ийм банкны. Мөн дээрээс нь Австрали зэрэг улсууд бол төрийн дансандаа аваад явж байдаг зохицуулалтууд байгаа. Ашигт малтмалын хууль дээр энэ зохицуулалт байхгүй. Энэ зохицуулалтыг Цөмийн энергийн хууль дээр оруулж ирээд, дараа нь Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга ч юм уу, нэмэлт, өөрчлөлтийн асуудал дээр хамгийн гол нь орд ашиглах эхлэхээсээ өмнө хаалтаа даах хэмжээний төслийг л хэрэгжүүлж

явъя л гэдэг манай яамны бол концепц байгаа. Зүгээр энэ дээр бол баталгаа гэдэг бол нэг ойлголт, мөнгөн хуримтлал үүсгээд явах нь бол бас нэг өөр ойлголт байгаад байгаа юм.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүний саналаар санал хураалт. 43,8 хувиар санал дэмжигдсэнгүй. 34.6. Энэ хуулийн, Энхтүвшин гишүүн яах юм бэ дараагийнх нь хураалгах юм уу? Саналаа татах уу? Микрофондоо хэлчих уялдаатай учраас гээд микрофондоо хэлчих.

**Д.Энхтүвшин:** Энэ санал маань нөгөө 34.6 дахь санал нь 34.5-тайгаа уялдаж байсан учраас 34.5 дахь санал дэмжигдээгүй учраас тэгээд энийг санал хураах, хураалгах шаардлагагүй байх гэж бодож байна, татаж байна.

**Р.Сэддорж:** 1 дүгээр зүйлтэй холбоотой санал хураалт дууслаа. Дараагийн зүйл дээр гишүүд бас идэвхтэй микрофон, дэгээр микрофон олдсон дээр юмнуудаа хэлж асууж. Энэ чинь эвгүй болчихсон юм байна. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Ганхуяг гишүүнээр тасалъя. Бадамсүрэн гишүүнийг оруулчихъя, орж ирж байна. Бадамсүрэн гишүүнээр нэр тасаллаа. Ж.Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

**Ж.Ганбаатар:** Хэд хэдэн асуулт байна. 4 номерын даргаас асууя. Энэ яг өнөөдрийн байдлаар энэ амнат-аа болон татваруудаа тултал нь авна гэсэн энэ ойлголт л энэ хууль байна л гэж ойлгож байгаа. Тийм учраас өнөөдрийн яг өнөөдрийн үнээр хэдэн хувийн амнат авахаар байна вэ? Нөгөө 5 дээр нэмэх нь 5, тэгээд өсөн нэмэгдэх байгаа шүү дээ. Тэгэхээр яг өнөөдрийн энэ протокол үлдэх хэрэгтэй л дээ.

2 дугаарт энэ орон нутгийн харилцаа Цөмийн энергийн тухай хуулийн

сул тал нь орон нутгийн харилцаа их бага байдаг юм шүү дээ. Манай 3 номерын дарга бас сайн мэдэж байгаа. Манай Уул уурхайн яамны залуу л даа. Тэгэхээр энэ орон нутгийн харилцаа гэдэг чинь уг нь тэр Энхтүвшин гишүүний хэлж байгаа хөрөнгө оруулагч талыг уг нь бол хамгаалдаг байх ёстой. Тэгэхгүй бол орон нутгийн харилцаа тодорхой биш байвал өнөөдрийн энэ үүсэж байгаа тэр янз янзын газар чинь үүсээд байгаа тэр зүйлийн чинь угтвар болдог юм шүү. Тэгэхээр тэр орон нутгийн харилцаагаа тодорхой болгох асуудлаар хуульдаа тодорхой зохицуулалт оруулбал яасан юм бэ? Нэгэнт л хууль хөндөж байгаа бол. Тэгээд хариулна биз.

Энэ 3 дугаарт энэ эцсийн бүтээгдэхүүн гэж үзэх үү? Бид нар нэг ажлын хэсэг дээр нэг баахан ярьсан даа. Хэрвээ эцсийн бүтээгдэхүүн гэж үзвэл НӨАТ-гүй болно доо. НӨАТ-ын татвар авч чадахгүй болно, буцаан олгоно гэсэн үг. Сангийн яамнаас хүн байгаа биз дээ? Тэгэхээр энэ чинь эцсийн бүтээгдэхүүн мөн юм уу, биш юм уу? Энийг бол нэлээн олон талаас нь ярьсан санагдаж байна. Тэгэхээр мөн гэж үзсэн юм уу ажлын хэсэг биш гэж үзсэн юм уу? Биш бол наадах чинь, биш гэж үзэж л татвараа бүгдийг нь авна гэсэн юм байлгүй дээ. Ямар логиктой орж ирж байгааг нь сонирхъё.

Сая тэр хаалтын санхүүжилтийг энэ хуулийн чинь 34.5, 34.6-д ЗГ-ын журмыг журмаар зохицуулна гээд заачихсан байна шүү дээ. Хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг тооцоолох байршуулах. Энэ чинь хуульдаа байвал зүгээр шүү дээ. Хэрвээ амжихгүй байгаа бол тэр юуны манай Ашигт малтмалын тухай хуульд бэлээхэн юу байж байгаа шүү дээ санаа байж байгаа. Тэр шинэ шинэчилсэн тэр юунд нь найруулга дээр нь байгаа. Энэ ЗГ-т олгогдвол наадах чинь ер нь бол үе үеийн янз янзын хүмүүсийн санаа оноогоор өөрчлөгдөөд, Их Хурлын эрх

мэдэлд хандсан юу халдсан асуудал болох байх шүү. Тийм учраас наад хаалт гэдэг зүйл чинь хамгийн чухал нь шүү дээ. Тэгээд байгаль орчинд холбоотой энэ гишүүдийн хөндөж байгаа хамгийн чухал зүйл нь. Тийм учраас энийгээ хуульдаа оруулбал яасан юм бэ?

**Р.Сэддорж:** Ганбаатар гишүүний асуултад гараа өргөөрэй 3 номер. 4 номер эхлээд, дараа нь 3 номер. 4 номерын микрофон өгье.

**С.Наранцогт:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Одоо зах зээлийн үнэ бол 80 гаруй доллар байна. Тэгэхээр манай энэ хуулийн төсөлд орсон Амнатын хуваариар бол 14 хувийн амнат төлөхөөр байна. Ер нь зүгээр энэ бүтээгдэхүүний нийлүүлэлт, цаашидын энэ баригдаж байгаа реакторууд болон цаашаа энэ төлөвлөлтийг бол бид нар харж байгаа. Тэгэхээр бол бүтээгдэхүүний нийлүүлэлт бол дутагдалтай байхаар ийм төлөв харагдаж байгаа. Өөрөөр хэлэх юм бол цаашидаа бол бүтээгдэхүүний үнэ нэмэгдээд явах юм байна гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Тэгэхээр энэ хамгийн багадаа бид нар 14 хувийн Амнат авна. Цаашидаа энэ амнат нэмэгдээд явна гэсэн ийм тооцоололтой байгаа.

**Р.Сэддорж:** 4 номер, 3 номер.

**Г.Намчинсүрэн:** Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Намчинсүрэн. Ашигт малтмалын тухай хууль дээр бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөгөө байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх зэрэг асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулна гэсэн заалттай. Энэ хүрээндээ энэ байгуулсан гэрээтэйгээ холбоотой бүх мэдээллийг олон нийтэд ил тавих, ил тавих зохицуулалт үйлчилж байгаа.

Яг энэ Цөмийн энергийн хууль дээр бол энэ зохицуулалт маань байхгүй байгаа. Бид нарын хувьд нөгөө Францын талтайгаа хэлцэл хийхдээ орон нутгийн асуудлыг маш анхааралтай, анхааралдаа авч хэлцэлд бол орж байгаа. Энэ дээр өөрөөр хэлбэл төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс жил бүр тодорхой хэмжээний 1 сая ам.долларыг, биш ээ худлаа ярьчихсан, тийм 1 сая ам.долларыг орон нутагтаа жил бүр өгөхөөр санал гаргаад явж байгаа. Тэгээд энэ асуудлаараа Францын талтай хэлцлийн явцад тохиролцоод, энийгээ орд ашиглах ТЭЗҮ-дээ тусгаад явж байгаа.

Нөгөөтээгүүр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд бол нэмэгдсэн өртгийн албан татварын тэг хувийг хэрэглэх асуудлыг уул уурхайн эцсийн бүтээгдэхүүнийг ЗГ батална гэсэн зохицуулалт бол байгаа. Энэ хүрээндээ таны хэлж байгаа үнэн. Одоогийн байдлаар ураны исэл буюу шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүний жагсаалтад оруулсан ЗГ-аас баталчихсан байгаа. Энэ асуудлыг Засаг дээрээ хэлцлийн явцад тохиролцоод, шийдээд явна гэсэн зохицуулалттай байгаа.

**Р.Сэддорж:** Ганбаатар гишүүн тодруулга авъя, микрофон нээе.

**Ж.Ганбаатар:** Тэр орон нутгийн харилцааг тодорхой болгосноор хөрөнгө оруулагч талыг хамгаална шүү. Тэгэхгүй бол ингээд орон нутгийн харилцаа чинь тогтвортой биш байгаа учраас ямар ч тийм ойлголтгүй учраас очоод орон нутагт чинь янз янзын юм ярихаар тэгээд өөрсдөө зохицуул гээд хаячхаж байгаа байхгүй юу. Тэгээд л өөр янз янзын юмыг нь тэгж болохгүй шүү дээ, ингэж болохгүй шүү дээ гээд салбараараа орилоод байдаг. Орон нутгийн харилцаа чинь тогтвортой хуультай байвал энэ чинь хөрөнгө оруулагч талдаа хамгаалалт болно. Тийм учраас хуульдаа тодорхой юм оруулах нь зөв байх.

2 дугаарт наад НӨАТ-ын чинь асуудал бүрхэг юм байна шүү. Татвараа бүгдийг нь авна гэж байгаа юм бол бүгдийг нь авах ёстой. НӨАТ гэдэг чинь хамгийн том татвар шүү дээ ер нь. Наад ААНОАТ-аас чинь хэд дахин илүү. Тийм учраас наад НӨАТ-ын чинь асуудал чинь хамгийн чухал татвар. Тэгэхээр наадхаа бид нар ажлын хэсэг дээр ярьсан шүү дээ Намчинсүрэн. Тийм учраас наадхаа тодорхой болгох хэрэгтэй.

2 дугаарт наад хаалт гэдэг чинь нэлээн тийм ЗГ шийдэх ёстой асуудал биш шүү дээ. Хуулийн дагуу шийдэх ёстой. Хуульдаа тодорхой оруулах ёстой шүү. Тэгж байж наад хууль чинь тогтвортой явна. Хөрөнгө оруулагч талаа хамгаалсан тогтвортой бүх юм нь ойлгомжтой байх хэрэгтэй. Тэгж байж наадах чинь, тэгэхгүй бол ойлгомжгүй юм болох л юм бол наадах чинь тэгээд л хэн дуртай хүн тайлбарлана шүү дээ, хэн дуртай хүн нь юм ярина. Тэгэхээр хууль өөрөө ойлгомжтой л байхыг сануулж хэлье. Би бол дэмжиж байгаа. Тийм учраас наадах чинь тогтвортой байгаасай гэж хүсэж байгаа юм. Дууслаа.

**Р.Сэддорж:** Санал гэж ойлголоо. Ганбаатар гишүүний хэлж байгаа зүйлүүд бол үнэн. Хуульдаа оруулж өгөхгүй бол зүгээр компанид нь хаяад, тэр компани чинь дураа хүрэхээр өгөөд, дургүйгээ хүрэхээр өгдөггүй шүү дээ. Тэгээд хуульд нэгэнт л өөрчлөлт орж байгаа бол энийгээ ингээд суулгаад явчихсан нь дээр шүү дээ. Стратегийн орд газар, стратегийн асуудлыг ярьж байгаа учраас ард иргэдэд энэ тодорхой байсан нь дээр байх. Ингээд Ганхуяг гишүүн, Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

**Х.Ганхуяг:** Өглөөний мэнд. Хуулийн санаа бол яах вэ дээ Амнат-н юун дээр л өөрчлөлт оруулах гэж байгаа л хууль байна л даа. Цөмийн энергитэй холбоотой нэг ч заалт байхгүй байна.

Дараа нь бид нар цөмийн энергийг ашиглахаар бол энэ хуульдаа нэмэлт, өөрчлөлт хийх гээд байна уу, яаж явах гээд байна вэ? Энэ Амнаттай холбоотой заалт байна. Энэ яригдаж байгаа энэ сэдэв маань өөрөө Ашигт малтмалынхаа хуулиар хангалттай явчихаар сэдэв байгаа байхгүй юу. Тэгээд яах юм бэ ингээд уран ашиглахтай холбоотойгоор ураныг олборлохтой холбоотойгоор бид нар ингээд тусад нь ийм хууль гаргаад, дараа нь газрын ховор дээр бас дахиад тусад нь хууль гаргаад ингээд явах юм уу гэдгийг бас нэг асуучихмаар байна.

Миний ойлгож байгаагаар бол шар нунтаг гэдэг маань анхан шатны боловсруулалт хийгдсэн ийм л бүтээгдэхүүн. Ашигт малтмалынхаа төрөлдөө л ордог юм. Ашигт малтмалынхаа хуулиар явдаг юм ихэнх оронд бол. Тэгээд ингээд нэг ийм жишиг л бий болгочихлоо л доо. Өнөөдөр бид нар ингээд хэлэлцэж байх хооронд тэр газрын ховортой холбоотой бас нэг ордын асуудал дээр ингээд л үймээн самуун болоод л, бослого болоод л яваад байна л даа. Тэгээд л тэрийг нь бас цацрагтай л гэнэ, бараг л урантай адилхан л юм яриад яваад байгаа байхгүй юу. Тэгээд яах юм бэ дараа нь бид нар газрын ховроо ашиглахаар бол дахиад тусад нь хууль гаргах юм уу гэдэг нэг асуулт байна.

2 дугаар асуулт болохоор энэ Амнаттай холбоотой асуудлыг бид энэ олон улсын энэ биржийн үнээр тогтооно гэдэг л ийм заалт орсон байна л даа. Бид нарын манай дотоодын биржийг бол ашиглахгүй юм байна гэж ойлголоо. Мөн үү? Ер нь бол яах вэ цөөхөн худалдан авагчтай ийм л салбар л даа. Тэгээд нөгөө Хятадын нэг биржийн үнийг бариад л, хямдхан зараад яваад байдаг ийм жишиг бас бий болчих вий. Тэгээд энэ талынхаа эрсдэлийг яаж харж байгаа, яаж цаашидаа хамгаалах юм бэ гэдэг асуулт байна. Нэг ёсондоо бид нар энэ татварынхаа орлогыг бүтэн авдаг баймаар байна л гэсэн үг.

3 дахь асуулт болохоор энэ хуулиар бид нар дараа дараагийн энэ ураны ордуудыг нээх, ашиглалтад оруулах гэрээ хийх бенчмарк буюу ийм загвар болох гээд байна шүү дээ. Тэгээд энэ дээр нэг асуудал нь юу вэ гэхээр эхний өнөөдөр ярилцаж байгаа тэр нэг Ораногийн орд байдаг юм уу, тэрэн дээр бол ингээд ЗГ бол жил шахуу ажиллачихсан, нэлээн шүүсийг нь шавхчихсан. Тэгэхдээ энэ нөгөө ордныхон тэндээсээ авах татвар гээд нэлээн шавхчихсан байдаг. Тэгээд энэ дээр чинь 20.6 дээр энэ бол дараагийн ордуудаа л ярьж байгаа юм шиг байгаа юм. Ашигт малтмалын нөөц ашигласны тухай тусгай төлбөрийн хувь хэмжээг тухайн ордын онцлог, ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшинийг харгалзан тогтооно гээд оруулчихсан байна л даа. Тэгэхээр дараа.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Ганхуяг гишүүний асуултад 4 номерын микрофон, 4 нээгдсэн байна.

**С.Наранцогт:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Бид нар анхны үедээ бол эхлээд Ашигт малтмалын хуулиар бас явах тухай явж байсан юм. Тэгээд ер нь энэ бол өөрөө бага хэмжээний цацраг идэвхтэй, тэгээд энэ орон нутгаас ялангуяа энэ цацраг идэвхтэй холбоотой янз янзын асуудал нэлээн яригдаж байгаа учраас Цөмийн энергийн хууль нь бол энэ цацраг идэвхийн зохицуулалт, хяналт эдгээр зүйлүүдээ нэлээн нарийвчилчихсан учраас ер нь зөвхөн энэ уран олборлох асуудлыг бол энэ Цөмийн энергийн хуулиар нь явуулаад энэ Амнат-н асуудлыг нь оруулаад явъя гэдэг ийм шийдэлд бол энэ ажлын хэсгүүд нэлээн ярьж байгаад шийдэлд хүрсэн юм. Тэгэхээр цаашидаа бол энэ ураны л олборлолт бол Цөмийн энергийн хуулиараа ингээд явна. Тийм учраас Цөмийн энергийн хууль дээр энэ асуудлаа яриад, зохицуулаад явах нь бол зүйтэй юм байна гэж ингэж үзсэн байгаа.

**Р.Сэддорж:** Бусад дээр нь хариулт өгөөрэй, дэлгэрэнгүй өгөөрэй, гүйцээж хариулъя, 4 номер.

**С.Наранцогт:** Бас зах зээлийн хувьд бол энэ их онцлогтой юм байна лээ. Энэ боловсруулалт хийдэг 5-хан улс байдаг, үнийн хувьд ч гэсэн ер нь 2-хон бирж олон улсын бирж дээр тогтоод явдаг. Тэгээд тэрүүгээрээ явдаг ийм зарчимтай учраас бид нар тэгж оруулж явж байгаа.

Тэр 3 дахь асуудал бол гэрээний хувьд бол энэ ийм байгаа юм. Ер нь бол аль ч гэрээний хөрөнгө оруулалтын гэрээний хувьд бол бид нар тэр тухайн ордын уул геологийн нөхцөл, орох хөрөнгө оруулалт, ашиглах технологиосоо хамааруулж бид нар энэ асуудлыг шийдэхгүй бол яг нэг төрлийн гэрээгээр бол энэ хөрөнгө оруулалтын гэрээ байх бололцоогүй юм байна лээ. Тийм учраас тэр тухайн ордын онцлог гэдэг зүйлээр авч үзэж байгаа юм. Энэ Зөвөч-Овооны хувьд бол газар доор уусган баяжуулах харьцангуй хөрөнгө оруулалт бага орох ийм технологитой учраас бид нар энэ дээр Амнатыг илүү өндрөөр тогтоод ингээд явах хувилбар нь илүү зохимжтой байна гэж үзэж байгаа. Зарим тохиолдолд бол бид нар энэ 34 хувиа үнэгүй авах, амнатаа өсөн нэмэх, хамтад нь явах бүх л хувилбарууд бол нээлттэй гэдэг байдлаар тэр томъёолол орж байгаа юм.

**Р.Сэддорж:** Ганхуяг гишүүн тодруулъя.

**Х.Ганхуяг:** Энэ дээр энэ Бадамсүрэн гишүүний яриад байгаа асуудал чинь яг энэ л заалттай чинь л холбоотой л асуудал байгаад байна л даа. Энэ хуульд ямар нэг өөрчлөлт оруулах бол, ашигт малтмалын нөөц төлбөрийг өөрчлөх бол зөвхөн ЗГ-ын саналаар өөрчлөлт оруулна гэхчхэн байгаа юм. Тэгснээ бид нар эхнийхээ гэрээгээ хийчхэнгүүтээ дараа дараагийн ордууд дээр болохоор та нар өөрсдөө дур мэдээд

л нөөц ашигласны төлбөрөө тавиад л, тогтоогоод л, гэрээгээ хийгээд л явах асуудал энэ дээр ингээд тавигдчихсан байна л даа. Тэгээд энэ асуудлыг л хаах гээд л арай жоохон буруу томъёолчихсон юм шиг байна л даа.

Тэгэхээрээ бид нар уран бол, боловсруулсан уран тэр тусмаа тээврийн зардал харьцангуй бага байдаг юм. Ер нь нээлттэйгээр хэзээ ч ураныг олборлодоггүй юм. Дандаа гүний уурхайгаар хийдэг эсвэл хамгийн сүүлийнх нь бол Ораногийн технологи байдаг. Тэр технологиор олборлохгүй юм бол одоо ер нь олборлохоо больчихоод байгаа юм даа ер нь. Тэгэхээр технологийн асуудлууд дээр та нар технологийн асуудлын ард ингээд дараа дараагийн юман дээрээ ингээд янз янзын юм оруулчих вий гэдэг л санаа зовнил байгаад байгаа юм шүү дээ гишүүдэд.

**Р.Сэددорж:** Хариулт 6 номерын микрофоныг нээе. Өөрийгөө танилцуулаарай.

**Д.Цолмон:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ Цолмон. Тэр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл..., тусгай төлбөртэй холбоотой асуудал бол ерөнхийдөө энэ 5.4 дэх заалтын хүрээнд буюу энэ төрийн эзэмшлийн хувь хэмжээг Амнатаар орлуулах тохиолдолд хэрэглэгдэх энэ тусгай төлбөрийн асуудал яригдаж байгаа. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ашигт малтмалын тухай хууль дээр бол энэ заалт бас мөн адил үйлчилж байгаа. Гэхдээ ялгаатай юм нь юу вэ гэхлээр яг энэ хувь хэмжээг хэрвээ Амнатаар орлуулах тохиолдолд тухайн Амнат-н дээд хэмжээг бол 5 хувиар тогтоочихсон байгаа Ашигт малтмалын хууль дээр. Энэ хувь хэмжээг Их Хурал шууд 5 хувь гэж тогтоогоод, 5 хүртэлх хувьдаа хэдэн хувь байхыг нь ЗГ өөрөө тогтоох ийм эрх мандатыг авсан ийм ийм хууль байгаад байгаа юм Ашигтай хууль дээр.

Цөмийн энергийн хуулийн энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр бол энэ олон эдийн засгийн үр ашигтай байх хувилбаруудыг тооцож үзээд, яг энэ хувь хэмжээг дээд, доод тааз тавихгүйгээр ЗГ өөрөө тооцоолж орж ирээд саналаа Их Хурлаараа батлуулах тийм л зохицуулалт байгаа юм. Өөрөөр хэлбэл доошоо, дээшээгээ хувь хэмжээний хязгаар бол байхгүй. Энэ зорилго нь юу вэ гэхээр Үндсэн хуулийн 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлт 6.2 дахь заалт энэ стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын энэ үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдох ёстой гэдэг 50 дээр нэмэх нь 1 гэдэг энэ хувь хэмжээг хангуулахын тулд энэ хувилбаруудыг тооцож үзээд, санхүүгийн тооцоолол хийгээд энэ хувь хэмжээ дээр бариулах, хэд ч байж болох ийм зохицуулалтыг тооцоолол хийх зорилгоор хувь хэмжээ бол тавиагүй байгаа. ЗГ-ын өргөн мэдүүлснээр гэдэг бол яг энэ зорилготой байгаа.

Харин та сайн харах юм бол энэ 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл дээр Улсын Их Хурал болон ЗГ-ын бүрэн эрх дээр бас энэ асуудлыг нэмж тусгасан байгаа. Өөрөөр хэлбэл энэ стратегийн ач холбогдолтой ордын хувь хэмжээг Амнат-р орлуулах, бас бүтээгдэхүүн хуваах ч юм уу энэ эдийн засгийн үр ашигтай хувилбарыг бол хэлэлцэхийг бол Улсын Их Хурал өөрөө бас санаачилга оруулж болохоор тавьсан байгаа.

**Р.Сэددорж:** Хариулт хангалтгүй гэж байвал нэмж хариулах уу? 5 номерын микрофоныг өгье.

**Н.Тэгшибаяр:** Ганхуяг гишүүний асуулт тэр сүүлийн технологитой холбоотой зүйл дээр хэлэхэд бол энэ ураныг олборлох хэд хэдэн арга байна. Газар доор уусган баяжуулах, ил уурхай, далд уурхай гээд энэ юутай холбоотой ингэж аргачлалыг сонгож байгаа вэ, технологи сонгож байгаа вэ гэхээр тэр анх хорвоо дэлхий үүсэхэд ямархуу



геологийн нөхцөлтэй байсан юм бэ гэдгээсээ болж байгаа.

Энэ Зөөвч-Овоогийн газар доор энэ уурхайн тухайд бол sand stone type буюу элсэн чулуулгийн төрлийн ийм орд, дэлхий дээр нэг ойролцоогоор 56-аас 60 орчим хувь нь бол газар доор уусган баяжуулах аргаар олборлож байгаа. Энэ хүлээн зөвшөөрөгдсөн ийм технологи учраас болбол яг ингээд геологи талаасаа, физик талаасаа энэ асуудал байхгүй. Харин өнөөдөр бол Эдийн засгийн байнгын хороо учраас эдийн засаг талаасаа л илүү сонирхолтой байж магадгүй.

**Р.Сэддорж:** Хариулт тодорхой гүйцэд биш учраас Ганхуяг гишүүн 1 минут өгье.

**Х.Ганхуяг:** Энэ нэгэнт Цөмийн энергийн хуулиа хөндсөн болбол бид нар энэ цөмийн энергиэ ашиглах талаар ер нь яагаад заалт оруулаагүй гэдэг дээр асуудалд ерөөсөө хариулсангүй л дээ. Уг нь бид нарын тэр ЗГ-ын мөрийн хөтөлбөр чинь бол тэгж яваад байгаа шүү дээ. Олборлоно, ашиглана, цөмийн энерги ашигладаг болно гээд. Бүр энэ 4 жилийн ЗГ-ын мөрийн хөтөлбөр чинь бол цөмийн станц хүртэл барих асуудал яваад л байгаа. Тэгээд энэ дээрээ байхгүй байхаар чинь тэр ажил нь явах юм уу гэдэг л асуултад ерөөсөө хариу өгсөнгүй шүү дээ. Хэн хариулах юм бэ?

**Р.Сэддорж:** 1 номер.

**Э.Нямдаваа:** Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Нямдаваа. Цөмийн эрчим хүчийг.../үг тасрав/

**Р.Сэддорж:** Туваан сайдын микрофоныг нээе, нээгдсэн байна.

**Ц.Туваан:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Энэ саяхан бид нар Улсын Их Хурлаар ЗГ-ын үйл

ажиллагааны хөтөлбөр баталсан. Энэ хөтөлбөр дотроо 14 мега төсөл гэж төслийг баталсан. Энэ дотор энэ ураны олборлолтыг явуулах Францтай холбоотой энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж, ашиглах гэдэг энэ зүйлийг нэг заалт болгож, 14 мега төслийнхөө нэг болгож оруулсан. Тэгээд энэ гэрээ хийх явцад бид бүхэн 2 талаас ажлын хэсэг суугаад, энэ гэрээний явц бол 60 орчим хувьтай ингээд 2 талаасаа асуудлуудаа тохиролцоод хийгээд ингээд явж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ бид бүхэн гаргалгаа гаргаж тухайлбал энэ Үндсэн хуулийн 6.2-т заасны дагуу энэ дийлэнх ашиг нь ард түмэнд байх гэдэг тал руу яваад, энэ дээрээ гаргалгаа гаргаад энэ төрийн мэдлийн хувийг энэ Амнат-н төлбөрөөр орлуулах гэдэг энэ концепцоороо энэ хуулийг оруулж ирж байгаа. Бас мөн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт болохоор энэ цөмийн реакторын асуудал байгаа. Тэгэхээр энэ цөмийн реакторын асуудал бол мэдээж цөмийн эрчим хүчийг гаргаж авах асуудал байгаа. Энэ асуудлыг бол нэлээн 10-аас 15 жилийн хугацаанд шийдвэрлэх маш олон жилийн хугацаа ордог ийм асуудал байгаа. Тэгэхээр ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт цөмийн эрчим хүчийг ашиглах, өөрөөр хэлбэл атомын цахилгаан станц ашиглах асуудлын суурь судалгааг хийнэ гэдэг байдлаар оруулаад энэ асуудлаа цааши нь авч явахаар тусгасан. Таны асуусан асуулттай холбоотой зохицуулалт, заалтууд бол Цөмийн энергийн хуульдаа угаасаа байгаа.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Бадамсүрэн гишүүний микрофон нээе.

**М.Бадамсүрэн:** Энэ 5 дугаар зүйлээс л асууя даа яг энэ хүрээнд нь. Тэгээд энэ төрөөс оролцох оролцооны талаар байна л даа. Тэгээд 5.1 дээр Монгол Улсын газрын хэвлийд оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмал төрийн өмч мөн гэж. Тэгэхээр төрийн

өмч мөн юм чинь энийг шийдэх эрх нь Их Хуралд байгаа юу эсвэл Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яаманд байгаа юу эсвэл ЗГ-т байгаа юу гэдгийг би Туваан сайдаас асууя.

2 дугаарт нь энэ Амнаттай холбоотой зүйл байгаа. Ер нь Амнат гэдэг чинь энэ газрын хэвлийд орох баялаг чинь хүний гараар бүтээгдээгүй, олон зуу, сая, мянган жилийн туршид бүрэлдэн бий болсон энэ эрдэс баялаг шүү дээ. Тэгээд энийг олборлож байгаа гэдэг утгаар нь АМНАТ-ийг аваад, энэ авсан ЗГ авч байгаа энэ төлбөрөөсөө 30-аас доошгүй хувийг нь тухайн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагт буюу тэр орон нутагт нь байгаль орчныг нөхөн сэргээх, хүн ардыг нь энэ орд ашиглаж байгаагийн хувьд насаараа энд эцэг өвгөдөөрөө эзэн болон суусных нь хувьд энд нутгийн иргэдийнх нь хөгжилд зориулах гэдэг л ийм л үндсэн агуулгаар энэ Амнат-г хуваарилдаг шүү дээ. Өөрөөр хэлбэл ЗГ татаж аваад 30-аас доошгүй энэ орон нутагтаа хуваарилдаг. Тэгэхээр энэ заалтыг энэ Цөмийн энергийн тухай хууль дээр яаж оруулж байгаа вэ?

Би Ганбаатар гишүүнтэй бол санал нэг байгаад байгаа юм. Энийг тодорхой болгож өгөхгүй бол болохгүй. Яагаад гэдгийг би хэлье. Яагаад, энэ 2 асуулт дээрээ бид тодруулж хэлье гэж бодож байна. Бид алдааг давтаж болохгүй шүү дээ. Оюу толгойн гэрээ Дубайн гэрээ гэдэг гэрээг Монгол Улсын Ерөнхий сайд байсан хүн Дубайд очоод байгуулчихсан. Энэнээс болж Монгол Улсад ноцтой хүнд байдал үүссэн. Энийг залруулахын тулд ямар их хүч хөдөлмөр, цаг хугацаа, ямар их алдагдсан боломж үүссэн, боломжийг алдсан бэ гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Тийм учраас энэ уран гээд цөмийн энэ цацраг идэвхт энэ том ордуудыг ашиглахтай холбоотой асуудал ингээд Улсын Их Хурлын хяналтаас, ЗГ-ын хяналтаас хол ингээд яваад байх юм уу?

Энэ хуулийн чинь 29.1-д заачихсан байна шүү дээ. Тусгай зөвшөөрөл олгосноос хойш 60 хоногт багтааж орд ашиглах гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулна гээд. 60 хоногт шүү дээ, 2 сарын дотор. Тэгэхээр энэ орд ашиглах гэрээг байгуулсан юм уу, байгуулаагүй байгаа юм уу? Энэ миний 3 дугаар асуулт. Энэ тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компанитай Орд ашиглах гэрээг байгуулсан уу? Энэ 29 дүгээр зүйл дээр чинь хэрвээ орд ашиглах гэрээг байгуулаагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно гээд заачихсан байна. Энэ процесс ямар шатад яваа вэ? Би энийг бас тодорхой дэлгэрэнгүй мэдэх хэрэгтэй гэж бодож байна. Амнат дээр нэмээд тайлбар хэлэхэд бол сайн дурын үндсэн дээр гэрээ байгуулна гэж Ашигт малтмалын тухай хууль, Засгийн.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Ажлын хэсэг, Туваан сайдын микрофоныг нээе.

**Ц.Туваан:** Тэгээд Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн 5.1 дээр Монгол Улсын газрын хэвлийд оришиж байгаа цацраг идэвхт ашигт малтмал төрийн өмч мөн гээд заачихсан. Та энэ асуудлыг ярьж байгаа байх. Тэгэхээр энэ хуулийг өөрөө Улсын Их Хурал маань баталсан. Тэгэхээр энэ хуульд ямраар заах асуудал бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал.

Дээрээс нь мөн Улсын Их Хурал, ЗГ хоёулаа юу гэдэг юм адилхан л Монгол Улсын эрх ашгийн төлөө ажиллаж байгаа. Нэг нь хууль тогтоох, нэг нь хууль хэрэгжүүлэх ийм үүрэгтэй учраас хуульд заасан эрх мэдлийг хэрэгжүүлээд явах нь бол ЗГ-т байгаа. Энэ ямар хэм хэмжээгээр, ямар хяналт тавих вэ, яаж зохицуулах вэ гэдэг асуудал Их Хурлын бүрэн эрхэд дотор байгаа гэдгийг хэлье.

Орд ашиглах гэрээг бол байгуулсан байгаа. 2016 онд энэ гэрээ бол байгуулагдсан явж байгаа гэдгийг хэлье. Тэгээд түрүүн би бас хэлсэн. Энэ бид нар

мэдээж Монголчууд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, Монгол Улсдаа ашигтай байх байдлаар л хийнэ. Өмнө нь бид нар бол тодорхой компанитай хөрөнгө оруулалтын анхны том гэрээг хийсэн. Энэ гэрээгээ нэг талдаа тавьж байгаад нөгөө талдаа энэ бол олон улсын 2 дахь гэрээ. Тэгэхээр түүн дээр гарсан алдаа, оноог гаргахгүй байх үүднээс, дээрээс нь Монгол Улсад 34 хувиар илүү ашиг ноогдох нь уу, угаасаа 34 хувиар авах нь авах эрх зүй нь бол хууль дээрээ байгаа. Тэгэхээр энийг арай илүү сайжруулж, 6.2 дээр дийлэнх буюу 50-аас дээш хувь нь ард түмэнд, улсад ноогдох байдлаар оруулж ирэхээр энэ хуулийн үндсэн концепц явж байгаа гэдгийг бас хэлье.

**Р.Сэддорж:** Өөр хариулах хүн байна уу? 4 номерын микрофон Амнат.

**С.Наранцогт:** Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Амнат бол Амнат нэрээрээ ингээд орлого төвлөрөх учраас одоогийн явж байгаа Амнатын зохицуулалтаараа л явна. Энэ дээр энэ Цөмийн энергийн хууль дээр тусгайлан ураны Амнат гэдэг зохицуулалт бол гаргаж ирээгүй, гаргаж ирэх ч боломжгүй. Энэ татварын хуульд заасан мөн яг сая таны хэлсэн Сангийн яаман дээр хийгддэг хуваарилалт яг энэ одоогийн явж байгаа журмынхаа дагуу хийгддэг явна гэж ингэж ойлгож болно.

**Р.Сэддорж:** Бадамсүрэн гишүүн тодруулъя.

**М.Бадамсүрэн:** Амнат төлөгч нь бол ингээд ЗГ төлбөрөө төлчхөж байгаа. Тэгэхээр энийг хэрхэн яаж орон нутагт хуваарилах вэ гэдэг асуудлыг л бид ийм цогцоор нь авч үзэх ёстой байхгүй юу. Үеийн үед ерөөсөө Сангийн яам, энэ Эрдэс баялгийн яам 2 энэ дээрээ судалгаа хийж, яг юунаас болоод энэ асуудал үүсээд байгаа юм бэ гэдгийг, тэгээд зөндөө л гадаад, дотоод явдаг юм шиг байна лээ шүү дээ. Тэгээд энэ гадаад баялагтай орнууд чинь сөрөг нөлөөлөлд

өртөж байгаа гэдэг утгаар нь Амнат-н орж байгаа төлбөрийг чинь хэд байдаг юм 100 тэрбум төгрөг орлоо гэхэд тэр 30-аас доошгүй тэрбумыг нь тэр сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагт нь хуваарилдаг олон улсын ийм зарчим байна. Энийгээ мөрдөхгүй болохоор ингээд хуваарилахгүй яваад байхаар тэнд өдөртөө тэр баялаг ашиглаад олон зуун машинаар нь гаргаад байдаг, тэр бүс нутгийн ард иргэд нь адилхан хөгжих ёстой биз дээ.

Түүнээс тоосонд даруулаад, амьдрах орчин нь доройтоод байвал энэ чинь олон улсын зарчим биш шүү дээ. Энэний чинь баялаг ашиглалттай холбоотой асуудал олон улсад энэ чинь олон жил явагдаад ирчихсэн. Тэгээд энийг яагаад ингээд хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ, энэ дээр дорвитой ийм шийдвэр гаргаач гэдэг энэ дээр яг ямар төлөвлөгөө байна вэ гэдгийг л би асуугаад байгаа юм. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах боломжтой эсвэл энэ хууль дээрээ заах боломжтой. Энийг тодорхой болгохгүй бол ингээд цаашидаа энэ ажил чинь явахгүй болчоод байгаа байхгүй юу. Энэ шалтгааныгаа, юунаас болоод байгаа шалтгааныгаа зөв олж тогтоох хэрэгтэй гэдгийг хэлээд байгаа юм. Энийг хуульд өөрчлөлт оруулах уу, ямар төлөвлөгөө байна вэ гэдгийг асуулт байна.

**Р.Сэддорж:** Туваан сайдын микрофоныг нээе.

**Ц.Туваан:** Яг энэ дээр уг нь бид бүхэн энэ Цөмийн энергийн хуулиа оруулж ирээд, дагуулаад бас Ашигт малтмалын тухай хуулиа оруулж ирье гэдэг ийм байдлаар явж байгаад энэ удаа дээр бол энэ зөвхөн нэг буюу цөмийн энергитэй холбоотой асуудал учраас Цөмийн энергийн тухай хуулиа оруулаад явъя гэдэг ийм шийдвэр гарсан юм.

Тэгээд түрүүн Ганбаатар гишүүн өмнө нь манай сайдаар ажиллаж байсан. Энэ орон нутгийн асуудлыг, мөн

Бадамсүрэн гишүүн ч гэсэн яг орон нутагт удирдаж ажиллаж байсан хүний хувиар маш зөв асуудлыг хөндөөд байгаа юм. Олон улсад энэ асуудлыг яаж шийдвэрлэх вэ, шийдвэрлэж байгаа вэ гэдэг асуудал бол ер нь бол маш өндөр анхаарал татсан ийм асуудал байгаа. Тэгэхээр бид бүхэн энэ Ашигт малтмалын тухай хуулийг бас удахгүй оруулж ирнэ. Олон улсад бол энэ Амнат-н хуваарилалтыг маш тодорхой болгох, өөрөөр хэлбэл улсын төсөвт нь хэд юм, орон нутагт нь хэд юм, тэгээд мөн тэр орон нутаг чинь дотроо аймаг гээд байна, манай Монголд бол сум гээд байна. Дээрээс нь тухайн ашигт малтмалын олборлолт явуулж байгаа тус бүс нутгийн иргэд гээд байна.

Тэгэхээр энэ дээр энэ Амнат-н хуваарилалтын менежмент гэдэг зүйлийг маш зөв оруулж ирээд, тэрийг нь яг бодитойгоор хуваарилаад явах юм бол тэр тухайн орд ашиглаж байгаа газар дээр орон нутгийн ч тэр, иргэдийн ч тэр асуудал ингээд шийдэгдээд явах боломжтой. Тэгэхээр энэ дээр бол бид нар хуульдаа яг энэ байдлаар өөрчлөлт оруулах талдаа ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Яг энэ Ораногийн төсөл дээр бол нийтдээ нэг төсвийн хугацаанд бол 5 тэрбум долларын ашиг олно гэсэн ийм урьдчилсан тооцоотой. Жилд орж ирэх орлого дотроос бол энэ улсын төсөв дээр 69, жилд 135 сая долларын орлого орно гэж төлөвлөснөөс улсын төсөв төсөвт 69 сая, орон нутагт 30 сая, мөн Баялгийн сангийн тухай хууль хэрэгжээд явж байгаатай холбогдуулаад энэ Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан 2-т нийт.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Өөр тайлбарлах хүн байна уу асуултад? Мөнхбаясгалан гишүүн.

**Л.Мөнхбаясгалан:** 2 асуулт байна. Энэ хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Монгол

Францын хамтарсан атомын цахилгаан станц барина гэж байгаа. Тэрийг бид дэмжиж баталсан. Энийг барих уу? 15 жил хүлээх нь их ядаргаатай гэдэг юм шиг юм яриад байгаа байхгүй юу. Үгүй ээ 15 жил, 20 жил хүлээе л дээ. Бид нар газрын тосоо Хятад руу экспортлоод, Оросоос эрчим хүчээ авдаг тийм тэнэг улс шүү дээ. Одоо тэгээд өөрсдөө ийм ураны нөөцтэй мөртөө эндээсээ яагаад эрчим хүчээ хангах боломжийг тавьж өгөхгүй зөвхөн шар нунтаг боловсруулахаар үлдээх гээд байгаа юм уу? Энд надад нэг сайн хариулаад өгөөч.

2 дугаар асуулт говийн бүсээс сонгогдсон гишүүний хувьд яг наад төсөл чинь хэрэгжих тойргийн гишүүний хувиар асуух асуулт байна. Аймагт, сумд ямар ач холбогдолтой юм бэ? Дээрээс нь бид бүс гэж ярина. Говийн бүсэд ямар ач холбогдолтой юм бэ? Ажлын хэсгийнхэн, сайд болохоор та нар нөгөө гэрээ дээр ажиллаад байгаа тийм үү? Бид нарт гэрээний тухай ямар ч ойлголт байхгүй. Зөвхөн энэ дээр өнөөдөр Цөмийн энергийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тал дээр орж ирэнгүүтээ бага, бага юм амсуулаад яваад байгаа байхгүй юу. Тэгээд Оюу толгойн гэрээг яриад байгаа. Оюу толгойн гэрээ чинь Хөрөнгө оруулалтын гэрээ нь зүгээр, хувь нийлүүлэгчдийн гэрээн дээр хамаг булхай нь байдаг. Дээрээс нь Дубайн гэрээгээр явсан юм. Тэрнээс биш зүгээр Оюу толгойн гэрээ бол ийм аймаар шүү. Тийм учраас энэ Цөмийн энергийн хуульд өөрчлөлтөө оруулах хэрэгтэй байна гээд шахаад байх шиг санагдаад байна. Ер нь баримт нь тийм шүү.

Тэгэхээр надад тодорхой хариулаад өгөөч. ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт байгаа тэр атомын цахилгаан станцыг /АЦС/ барих юм уу, барихгүй юм уу? Тийм шаардлагатай бол одоо нэгэнт хуульд өөрчлөлт хийж байгаа бол шууд хуульдаа өөрчлөлт хийгээд л явъя л даа. Дараа нь тэр аймаг, орон нутаг, сумд та нар соён гэгээрүүлэх ямар ажил хийж байгаа юм бэ? Манай

тойргийнхонтой юу ярих гэж байгаа юм бэ? Энэ талаараа нэг тайлбарлаад өгөөч.

**Р.Сэддорж:** Туваан сайдын микрофоныг нээе.

**Ц.Туваан:** Мөнхбаясгалан гишүүн маш чухал асуудлуудыг хөндсөн. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт цөмийн АЦС-ын суурь судалгааг эхлүүлнэ гэдэг байдлаар оруулсан. Энэ нь бол ямар ч байсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон учраас энийг бид нар биелүүлэх ёстой, энэ ажлыг урагш нь ахиулах ёстой. Бид нар энэ ураны исэл олборлож байгаа, шар нунтаг олборлож байгаа ийм ураны нөөцөөр дэлхийн эхний 10-д орж байгаа орны хувьд энэ чинь АЦС гээд л бид нарын нэг атомын бөмбөг гэдэг шиг айгаад байдаг асуудал болохоос биш ер нь бол энэ атомын эрчим хүч, цөмийн эрчим хүчийг ашиглах гэдэг бол дэлхийд маш хямд эх үүсвэртэй. Яг стандартын горимыг нь мөрдөөд ашиглавал энэ нөгөө нүүрсхүчлийн хий ялгаруулах энэ тэр гэдэг дээрээ бол маш бага нь тогтоогдчихсон ийм ажил. Тэгэхээр энийг бид нар барьж авч цаашидаа ажиллана. Энэ яг эхлээд яриад тэр цөмийн бага юм уу, дунд оврын реактор ажиллагаанд орох хүртлээ хугацааг 10-аас 15 жил гэж ингэж харж байгаа. Энэ дээр манай Цөмийн энергийн комиссоос нэмэлт хариулт өгчхөөрэй. Яг энэ хугацаанд Монгол Улсад энэ цөмийн бага, дунд оврын реактор ашиглах талаар бас нэг олон улсын хурал явагдаж байгаа. Энэ талаар манайхан нэмэлт мэдээлэл өгчхөөрэй.

2 дугаар асуудал дээр бол яг аймаг, сумд ач холбогдолтой гэдэг дээр бол түрүүн би хэлсэн. Түрүүний 130 хэдэн сая доллар жилдээ энэ төслөөс ноогдоно гэж үзвэл 35 сая долларыг орон нутгийн төсөвт оруулахаар ингээд урьдчилан төсөвлөсөн явж байгаа. Мөн гэрээ бол яригдаж байгаа. Тэгэхээр нөгөө Оюу толгойн гэрээтэй холбож ярихад бид нар аль алийг нь тавьж байгаад л нэг талд нь

тавьж байгаад л энэ гэрээгээ гэрээн дээрээ ажиллаж байгаа. Тэгэхээр мэдээж дахиж алдахыг бол хүсэхгүй ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Орон нутгийн сумд нь бол тодорхой жилдээ 1 сая долларыг бол өгөхөөр байдлаар энэ гэрээнд явж байгаа. Энэ давуу эрхийн хувьцаа бол тэртээ тэргүй 10 хувийн хувьцаа байгаа. Тэгээд энэ дээр бол бид нар ямар нэгэн Монголын талын хүлээх буюу төлөх Оюу толгой шиг төлөх мөнгө бол байхгүй. 34 хувийн асуудал яригдаад явахаар бид нар 34 хувьдаа яг энэ төсөл дээр гэхэд л төсөв гэрээ зурагдаж эхлээд л 125 сая доллар төлөх энэ асуудлууд ингээд яригдаад явж байгаа. Тэгэхээр бид нар энэ байдлаа сонгоод амнатуудаа тултал нь аваад явах нь Монгол Улсын хувьд бол ашигтай гэдэг ийм байдлаар харагдаж байгаа.

Бид нар тун удахгүй Казахстанд энэ цөмийн энергийн казатомтой энэ реакторын асуудал, дээрээс нь энэ тэнд хэрэгжүүлж байгаа энэ уран олборлох асуудлуудтай танилцах энэ асуудал явж байгаа. Тэгээд энэ хүрээндээ Ораногийнхантай Монгол тал нь ч тэр, Франц тал нь ч тэр санал тохирсон нэг зүйл бол нутгийн ард иргэдийг бас яг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

**Л.Мөнхбаясгалан:** Тэр соён гэгээрүүлэх ажил дээр хариулт авна шүү. Бид нар урантай улс мөртөө зөвхөн шар нунтаг дээр зогсвол бид нар дэлхийд байхгүй тэнэг улс болно. Бид нар АЦС барина гэж заавал энэ хуульдаа бүр Туваан сайд оруулаад өгчихмөөр санагдаад байгаа юм. Цөмийн технологи өндөр хөгжссөн оронтой хамтран эсвэл олборлож байгаа тэр тухайн хөрөнгө оруулагч нь тийм үүрэг хүлээж болно шүү дээ. Нэгэнт энэ хуулийг барьж авсан бол хийх ёстой. Тэгэхгүй бол бид нар хэдэн жилийн дараа яг одоогийнх шигээ

газрын тосоо гадагшаа экспортлоод өөрсдөө Оросоос хараат тогны хараат, Хятадаас хараат, Оюу толгой нь хүртэл хараат ингээд байж болохгүй биз дээ. Энийг хуульчлах тал дээр ЗГ, ажлын хэсэг ажиллаад өгөөч. Тэгэхгүй бол бид нар дахиад хэдэн жилийн дараа энийг эргүүлж орж ирнэ гэвэл худлаа болно. Энэ 2 дээр дахиад надад хариулт өгөөдхөөч.

Нэг нь тэр соён гэгээрүүлэх ажил нутгийн ард түмэнтэй ажиллах. Нөгөөдөх нь энэ хуулийн заалтдаа ингэж өөрчлөлт оруулахгүй юм уу? Одоо дөнгөж 1 дүгээр хэлэлцүүлэг шүү дээ.

**Р.Сэддорж:** Туваан сайд хариулъя. Туваан сайдын микрофон.

**Ц.Туваан:** Мэдээж сурталчлан таниулах гэдэг бол маш чухал. Монголчууд мянга сонсохоор нэг үз гэдэг. Тэгэхээр яг энэ ажлыг бол 2 талаас хамтарсан компанийн хувьд бол ярьж байгаа. Нутгийн, орон нутгийн иргэдийг яг тэр иймэрхүү төсөл хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай авч явж танилцуулах гэдэг ажлыг бол хийхээр тохиролцоод явж байгаа.

Тантай яг агуулгын хувьд тэр цөмийн шар нунтаг олборлох болон цөмийн энерги ашиглах гэдэг дээр бол яг адилхан байр суурьтай байгаа. Яагаад вэ гэхээр бид нар энийг нэгэнт олборлож, ашиглаж байгаа юм чинь энэ Улаанбаатарт байгаа энэ утаатай, түгжрэлтэй байдал, дээрээс нь энэ эрчим хүчний дутагдалд орчихсон байгаа байдал зэргүүдээсээ энэ нөхцөл байдлын байдлаа ашиглаад атомын бага, дунд оврын реактор ашиглах байдлаар гарах гэдэг энэ зүйл дээр бол санал нэг байгаа. Энэ талаар бол хуульдаа бас цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд баримтлах журам гээд мөн зааврыг нь гээд ингээд хууль дотор бол заагаад өгчихсөн байгаа. Тэгээд тантай бас энэ талаар ярилцъя. Бид бүхэн бас ажлын

хэсэг дээрээ энэ цаашидынхаа асуудлыг, нэгэнт олборлож байгаа бол бид нарт шар нунтаг нь байгаа бол эндээс яаж эрчим хүч ашиглаж, тэр хямд бөгөөд хүлэмжийн хий бага ялгаруулдаг эрчим хүч ашиглах тал дээрээ бол тодорхой ярилцъя.

**Р.Сэддорж:** Цөмийн энергийн, гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдээс асуулт асууж, хариулт авч дууссан байна. 2 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

**Л.Соронзонболд:** Энэ нөгөө 5.2, 5.3-д заасан хувь хэмжээг ЗГ-ын өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно гээд оруулж байгаа хэсэг дээр өнөөдрийн зах зээлийн үнэлгээгээрээ бид нар бол Монгол Улс төр 34 хувь эзэмших байсан. Тэгэнгүүт бид нар давуу эрхтэй 10 хувь болгож өөрчилж байгаа. Тэгэхээр нөгөө өнөөдрийн үнэлгээгээрээ байгаа 34 хувийнхаа 24 хувийг бид нар ямар хугацаанд энэ амнат-аар дамжуулж нөхөж авахаар тооцож байгаа вэ гэдэг бол нарийн асуудал байхгүй юу.

Тэгэхээр бид нар энэ борлуулалтын орлогын хэмжээнээс нь 5 хувиар гээд бодтол зах зээлийн үнэлгээнээс чинь хэд дахин багаар борлуулалт нь яваад байвал бид нар 30 жилийн дараа 24 хувийнхаа зөрүү мөнгөө авах юм уу? Яг хэзээ вэ, энэ дээр ер нь санхүүгийн тооцооллоо яаж хийж байгаа вэ гэж асуумаар байна.

**Р.Сэддорж:** Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Энэ дээр чухал асуудал. Ер нь бол манай Амнат чинь одоо бол суурь Амнат 5 хувь, тусгай Амнатыг бол бид нар гэрээний дотор бол тултал нь буюу 5 хувиар авахаар. Дээрээс нь өсөн нэмэгдэх Амнат бол хуулиараа тэгээс 9 байгаа. Тэгээд энийг бид нар шар нутгийн үнийн үнэтэй уялдуулан нэмэгдүүлэх байдлаар тэгээс 9. Тэгэхээр энэ бол дэлхий дээр 440 гаруй реактор, дахиад бараг 300 гаруй реактор төлөвлөгдөж байгаа энэ үед бол шар нутгийн үнэ өсөх нь бол тодорхой байгаа. Эрэлт маш өндөр байгаа. Тэгэхээр энэ өсөж байгаа үнэтэйгээ уялдуулаад тэгээс 9 гэхээр өнөөдрийн байдал дээр 14 хувь буюу нийтдээ 14, цаашаа ингээд нэмэгдэхээр байгаа. Тэгэхээр бол энэ нэлээн 19, 17, 8, 19 рүүгээ явах магадлал ойрын жилүүдэд өндөр.

Дээрээс нь энэ дээр энэ бас тодорхой хэмжээний татварын хуульд энэ оруулсан тогтворжуулсан татваруудаас гадна Монгол Улсын хууль тогтоомжоор бас нэлээн олон төрлийн тухайлбал байгаль орчны, усны, газрын энэ тэр гээд татварууд байдаг. Эдгээр татваруудыг ер нь бүгдийг нь нийлүүлээд тооцож үзэхэд Үндсэн хуулийн 6.2 буюу 50 дээр нэмэх 1-ийгээ бол ер нь хангахаар байгаа. Хөрөнгө оруулалтын гэрээн дээр айлын тал ч гэсэн бас танай дээр явж байгаа энэ татваруудыг нэмээд үзэхэд танай хууль тогтоомжийг аль хэзээ хангаад давахаар ийм нөхцөл байдал байгаа гэдгийг ярьж байгаа. Яг тодорхой хэдэн жилд 34-ийг 10 болгоод, зөрүүлээд энэ амнатуудаа тавихад хэдэн жил гэдэг дээр манай Мон-Атом хариулах уу, тооцоолол байна уу? Яг тодорхой гишүүний тодорхой хугацаа дээр хариулт өгчих.

**Р.Сэддорж:** 9 номерын микрофон нээе.

**Ц.Туваан:** Хэдэн жилд нөхөхөөр тодорхой болж байгаа вэ?

**Р.Сэддорж:** 9 номер.

**А.Алтанхундага:** Сайн байна уу? Таны асуултад хариулъя. Мон-Атом компанийн инженер Алтанхундага байна. Энэ судалгааг бол хийсэн. Ер нь 34 хувьтай явж байхад бид хэд 13,2 жил, 2 жилийн дараа хөрөнгө оруулалтаа нөхөөд, ноогдол ашгаа авахаар судалгаа. Харин төрийн эзэмшлийн хувиа 10 хувиар орлуулахад бид нар Амнатаа шууд 28 оноос борлуулалт эхэлснээсээ шууд хүртээд явах боломжтой болж байгаа. Давуу эрхийн хувьцаа болгосноор.

**Р.Сэддорж:** Соронзонболд гишүүн тодруулъя.

**Л.Соронзонболд:** Яах вэ нөгөө гол нь Амнат маань өөрөө борлуулалтын орлогоос хамаараад байгаа байхгүй юу. Тэгтэл борлуулалтын орлого чинь хэрвээ төсөөлснөөс бага байвал бид нар та хэдийн тооцоолж байгаагаар 13 жил, нөгөөдөх нь бараг 4, 5 жилийн дараа нөхөөд эхлэх юм шиг яриад байна шүү дээ. Тэр чинь хойшлох тийм асуудал байх вий л гэдэг болгоомжлол байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас өнөөдөр байгаа 24 хувиа л зарж байгаа улсууд шүү дээ бид нар. Тэгээд тэрийг аягүй сайн бодох ёстой байх л гэж хэлмээр байна.

**Р.Сэддорж:** Санал уу? 4 дээр тодруулъя. 4.

**С.Наранцогт:** Соронзонболд гишүүний асуултад тодруулаад хариулчихъя. Ер нь би түрүүн бас хариулсан. Ер нь ноогдол ашиг, Амнат 2-ын баланс бол баталгаатай орлого, баталгаагүй 2 орлогыг баланслах тухай л асуудал байгаа юм. Тэгэхээр бид нар 34 хувь аваад үнэгүй аваад, тэгээд тооцоолол хийж үзэхэд бол боломжийн аятайхан тооцоолол гарч байгаа. Гэхдээ яг таны хэлдэг шиг зардал нь ихсээд

ингээд бид нарын шүүмжлээд байдаг асуудлууд үүсээд ноогдол ашиг хуваарилах асуудал хойшлоод ирэх юм бол хэдийгээр гэрээ байгуулах үед орлого сайн юм шиг, ноогдол ашиг гайгүй авчих юм шиг харагдах боловч яг баталгаатай орлого биш.

Тэгээд сая Алтанхундагын тайлбарласнаас бид нар амнат-аа нэмж чадах юм бол өнөөдөр бол бид нар 14 хувийн Амнат шууд борлуулалт эхлэнгүүт аваад явна. Үнийн хувьд бол би бас тооцоолол түрүүн ярьсан. Өнөөдөр дэлхий дээр 440 реактор ажиллаж байна. 60 реактор шинээр баригдаж байна. Барихаар төлөвлөж байгаа 431 реактор байгаа юм байна. Тэгээд энийг бас бид нар судалж үзсэн. Тэгээд зах зээлийн үнийг эрэлт, нийлүүлэлтээрээ л зохицуулагдана энэ мэдээж. Тэгэхээр энэ саяын энэ төлөвлөлтөөр харахад ер нь энэ бүтээгдэхүүний хомсдол бий болохоор байгаа. Ингээд бид нарын олон улсын эх сурвалжаас нь аваад үзэхэд бол 2050 он хүрэхэд бол уран 200, үгүй биш ээ 177 долларын энэ шар нунтгийн үнэ хүрэхээр ийм байнга тогтмол өсөлттэй ийм судалгааны дүнгүүд гарч байгаа юм.

Тэгээд энэ утгаараа бол бид нар ингээд баталгаатай орлого маань үнэ нь тогтмол нэмэгдээд явах учраас улам нэмэгдээд явна гэсэн ийм тооцоололтой байгаа. Тэгээд энэ сүүлд нь бол Туваан сайд бас хэлээд байгаа. Бид нар ямар ч тохиолдолд Монгол талын шууд хүртэх өгөөжийг бол Үндсэн хуулийн 6.2-т заасан 50 дээр нэмэх 1-ийг хангана гэдэг заалтыг хөрөнгө оруулалтын гэрээндээ оруулна гэж ингэж хөрөнгө оруулагч талтай тохирч байгаа. Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр бид нар ямар ч тохиолдолд Монгол талын шууд.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүнийг үг хэлэх гишүүнд нэмээрэй. Ж.Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Энэ нэг ашигт малтмалын бусад баялгууд дээр чинь нэг сорчлон ашиглах гэдэг ойлголт байгаа. Тэгэхээр энэ уран дээр яаж мөрдөгдөх вэ? Энийг нэг хэлээрэй, яг ажлын хэсэг дээр бас тодорхой биш байдаг байсан юм. Сорчлон ашиглах гэдэг асуулт байгаа гэдгийг хэлье.

Энэ сая энэ Соронзонболд гишүүний асуултад хариулахдаа энэ зэсийг чинь Лондоны биржийн үнээр татвараа авдаг юм шүү дээ Амнатаа авдаг. Уран чинь адилхан биз дээ. Тэрийгээ хариул л даа. Тэрийгээ наад микрофондоо үлдээх хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй бол тэр хүмүүсийн зарсан үнээс авна гэж байхгүй шүү дээ. Лондоны биржийн үнээр юм уу, биржийн үнээс Амнат авна гэдгийгээ тодорхой хэл л дээ. Тэрнээс гадна үнэ буусан ч, биржийн үнэ буусан ч суурь Амнат чинь 10 хувь шүү дээ. Тэрийгээ бас тодорхой хэл. 10-аас доошоо буухгүй гэдгийгээ хэлэх хэрэгтэй шүү дээ.

Зөвхөн нөлөөлдөг, үнэд нөлөөлдөг Амнат чинь тэр 4 хувь чинь байхгүй юу. Тэгээд одоогийн өнөөдрийн яриад байгаа тэр өсөн нэмэгдэх гэдгийг. Тэгэхгүй бол энэ гишүүд чинь үнэ буугаад байвал Амнат нь буугаад байх юм шиг ойлгоод байх шиг байна шүү дээ. Тэрийгээ бас хэлээрэй. Тэгээд сорчлон ашиглах гэдэг дээр.

Тэгээд сая энэ Бадамсүрэн гишүүний хэлсэн тэр Амнатын хувьд бол энэ чинь ирээдүйд хадгалах ёстой мөнгө шүү дээ. Урсгал зардалдаа тавиад туучих ёстой татвар биш, цалин пүнлүү, дулаан юу байдаг юм. Сая тэр Бадамсүрэн гишүүн юуг нь хэллээ шүү дээ энэ чинь ямар татвар билээ гэдгийг нь. Тэгээд сая энэ 4 номерын дарга яагаад чимээгүй байж байгаад батлуулчхаж байгаа юм. Сая төсөв батлахдаа Ирээдүйн өв санд 70 хувийг нь хуримтлуулна гээд дөнгөж сая сонгуулийн өмнө батлагдсан хуулийг 40 хувь болгоод төсөв батлахдаа



бууруулаад оруулаад ирж байгаа юм. Тэрийг мэдэж байсан юм уу, мэдэхгүй байсан юм уу, хажуу тийшээ харахыг бодоход мэдэхгүй байсан юм уу. Тэр бүүр ухралт болж байгаа байхгүй юу.

Тэгээд би хэлээд байдаг. Ер нь хуучин гишүүдийн үг ер нь үг биш болчихсон юм шиг байна лээ шүү. Ер нь нэг их тийм дуу хоолой нь их багасчихсан юм шиг байна лээ. Тэгэхээр хэлээд байхад тэр үгийг ер нь хүлээж авахгүй. Наадах чинь 40, 70 байсан нь уг нь 100 руу орох ёстой шүү дээ. Явах ёстой. Энэ мөнгө чинь бусад улсуудад яадаг билээ бүгдээрээ тойроод суугаад ярьсан шүү дээ. Маши гоё, гоё улсуудын жишээ ярьсаар байгаад 70 хувь болсон. Тэгээд сая буцаад 40. Тэгээд уг нь бол наадах чинь бол зүгээр энгийн татвартай харьцуулах мөнгө биш байхгүй юу. НӨАТ юм уу, ашигт юу ашгийн татвар юм уу, цалингийн орлогын татвараас шал өөр мөнгө. Энэ мөнгийг бол бид ирээдүйд ашиглах ёстой, орон нутагт нь тэр олборлуулж байгаа орон нутгийг нь өөд нь татах ёстой. Шинэ хуулиар 30 хувь байгаа. Тэрийгээ.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Ганбаатар гишүүний үгийг микрофонд хэлье. Энэ шууд борлуулалт яваад эхлэнгүүт энэ борлуулалтын хэмжээнээс авах татвар бол энэ Амнат. Олон улсын 2 бирж дээрх үнийг шууд аваад л, тэндээсээ бодоод 10 хувиа бол шууд 5 дээр нэмэх 5-аа, өсөн нэмэгдэхээ бол тухайн үеийн үнээсээ шалтгаалаад ингээд 14 үү, түүнээс дээш байх уу гэдэг асуудлууд явчихна. Дээрээс нь энэ дээр тэр 50 дээр нэмэх 1 гэдэг дээр ярихад бол энэ 19 хувь, дээрээс нь ААНОАТ, дээрээс нь бусад татварууд ингээд нэмж байгаад 50 дээр нэмэх 1 гэдэг энэ зүйл бол босож ирэх юм гэдгийг хэлье. Сорчлон ашиглах дээр манай хэн 5, дараа нь.

**Р.Сэддорж:** 5 номерын микрофон өгье.

**Н.Тэгшибаяр:** Энэ газар доор уусган баяжуулах арга яг энэ sand stone буюу ингээд элсэн чулуулаг төрлийн ордод таарсан. Тэгэхээр түүн дотор байгаа ураны, уран 308-ыг бол бүрэн юу гэдэг юм тэр авах боломжтой, сорчлох боломжгүй л. Энэ технологи нь тэр сорчлоод байх юм байхгүй л гэсэн утгатай. Тийм.

**Р.Сэддорж:** Нэмэлт тайлбар байна уу? Тодруулга Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Би ингэж асуусан юм. Нөгөө сорчлон ашиглана гэхээр наад дээр чинь 60 хувь гэдэг тоо яваад байсан юм. Тэгэхээр яг та нар яг юу гэж үзэж байгаа юм бэ, 60 хувиа аваад, 40 хувийг нь үлдээчих нь зөв гэж үзэж байгаа юм уу? Бусад ашигт малтмал дээр бол бид нар тэрийг зөвшөөрөхгүй шүү дээ. 100 хувь авахыг. Эдийн засгийн хувьд ашигтайг нь аваад, ашиггүйг нь үлдээчихнэ гэвэл энэ уул уурхай чинь бол төрийн бодлого чинь ер нь бүр сонин болно шүү дээ. Энийг чинь л сорчлон ашиглана гэж байгаа юм. Тэгэхээр уран дээр чинь яах, ямар бодлого барих ёстой юм бэ? Яг аль нь зөв юм бэ? Агентлаг юу гэж үзэж байгаа юм бэ? Агентлаг л өөрсдөө л наадхын чинь юу шүү дээ. Тэгээд яаж ашиглавал зөв юм бэ? Бусад ашигт малтмал дээр бол Уул уурхайн яам бодлогын хувьд бид бол сорчлон ашиглахыг зөвшөөрөхгүй шүү дээ. Сайныг нь аваад, мууг нь орхино гэсэн үг шүү дээ. Тийм байж хэзээ ч болдоггүй юм. Тэгэхээр наад дээр чинь ёстой яах ёстой юм бэ? Тэр 60 хувь чинь хэвээрээ байгаа юм уу? Тэгээд энэ асуултад хариулж өгөөч.

**Р.Сэддорж:** 3 номерын микрофоныг нээе.

**Г.Намчинсүрэн:** Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Намчинсүрэн. Энэ компани бол эдийн засгийн үр ашигтай нөөц нь 69 мянган тонноор яваа. Өөрөөр хэлбэл геологийн нөөц нь 100 гаруй мянган тоннтай. Тэгээд эдийн засгийн үр ашигтай буюу ашиглалтад өртөх нөөц нь 69 мянга. Сая Тэгшибаяр доктор хариулж байна. Үндсэндээ бол газрын дор уусган олборлох технологид уран 308 хүхрийн хүчил юуг шахаж өгснөөр тэр элсэн дэх уран бүрэн уусаад явах боломжтой. Технологийн хувьд бол ийм технологи байгаа.

**Р.Сэддорж:** Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Сайн байцаана уу? 3 дугаар зүйл, 5-ын, асуух уу? Энэ яг нөгөө Сэддорж даргын гаргасан энэ горимын зөрүүтэй саналын томъёололтой холбоотой ийм асуулт байна минийх. 5.3, 5.4-тэй холбоотой гэсэн үг. 5.3 дээр илүү гарсан хувийг төр үнэ төлбөргүй эзэмшинэ гэсэн байгаа шүү дээ. Тэгээд тэрнээс дээш хуучин хуулийн заалтаараа болохоор 5.3 дээр уг хувийн гээд хэлчихсэн байгаа. Одоо ингээд Сэддорж даргын оруулж ирж байгаа горимын зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр илүү хувиар гэдэг дээр нөгөө бүтээгдэхүүн хуваах энэ тэр гээд яригдаж эхэлж байгаа. Тэгэхээр энэ дээр маш сайн анхааралдаа авахгүй бол энэ хууль уул уурхай уран жишигээр зэсийн баяжмалыг олборлоход гарсан тэр гэрээний хуулийн заалтууд арай өөр агуулгатай байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэ 34 хувиас нэмэх хувь дээр энийг ярьж байна уу эсвэл одоо энэ орж ирсэн заалт дээр нээлттэй яриад байна шүү дээ энэ нөгөө нэмэлт, өөрчлөлтийн хууль дээр. Сэддорж даргынх дээр болохоор илүү хувь гээд. Энэ дээр би яг асуулт асууя гэж бодож байсан. Тэгээд энэ саналын томъёолол оруулж ирсэн учраас энийг дахин давтаж хэлээд байгаа юм. Тэгэхээр өмнө нь хэлсэн Соронзонболд гишүүний хэлж байгаа, юу асууж байгаа асуулттай

санал нэг байгаа юм. Энэ үнэ төлбөргүй хувь, түүнээс дээш илүү гарсан хувь дээр гэдэг дээр ач холбогдол өгөөрэй. Маш сайн тодорхой яахгүй бол энэ дараа нь маргаан дагуулах вий гэж бас санаа зовж байна.

2 дугаарт тэр тооцоолол дээр бас зөндөө асуучихлаа. Сая хамгийн сүүлд Соронзонболд гишүүн асуучихлаа. Аргачлал ярьж байгаа. Хамгийн гол нь бид нарын санаа зовж байгаа юм бол Амнат-н 5 хувь дээр нэмэх нь 5 хувь, тэгээд нэмнэ нэмээд үнэ нэмэгдвэл өсөн нэмэгдэх татвар ноогдуулах татвар хувь. Эд нарын тооцоолоор бид нар 34 хувиа болиод, олж байгаа энэ орлого чинь ирээдүйн үнэ цэнийг тооцоход яг энэ ашигтай байж чадаж байна уу, 34 хувийг үнэ төлбөргүй эзэмших байснаасаа давуу гарч чадах уу? Энэ тооцоолол дээрээ маш сайн анхаараарай л гэдэг, энэтэй холбогдуулаад хариулт бараг зөндөө сонслоо. Нэмж тайлбар байвал сонсьё. Энэ дээр маш анхааралтай хандахгүй бол энэнээс болоод л Оюу толгой төсөл бас аягүй олон удаад удаа дараалан олны анхааралд өртөж байсан ийм зүйлүүдээ тодорхой анхнаас нь тайлбарлаад явах ёстой байх.

Нэмж сануулж зүгээр хэлмээр байгаа зүйл нь засаглалын асуудал маш чухал байдаг. Холбогдох, харьяалагдах, ажиллах засаглалын асуудал, тэгээд мэдээллийн нээлттэй, ил тод байдал бас маш чухал. Мэдээлэл далд байснаараа мэдээж угаасаа ийм орлоготой газар анхаарал төвлөрсөн байдаг. Мэдээлэлгүй хүмүүс яах билээ сэрдэнэ ийм л зүйлүүд болдог шүү. Тэгэхээр маш том ач холбогдол өгөөрэй л гэж хэлэх гэсэн юм.

**Р.Сэддорж:** Хариулт, Туваан сайдын микрофоныг.

**Ц.Туваан:** Бид нар 3Г-ын зүгээс ажлын хэсэг хэлэлцээрт орж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бол таны хэлсэнчлэн онцгой анхаарч ажиллана.

Тэр хувь хэмжээний хувьд асуудал дээр бол төрийн эзэмших хувь хэмжээ дээр бол төрийн зардлаар хайгуул хийсэн орд дээр бол 51 хүртэл хувь, хувийн зардлаар хайгуул хийж, хийсэн орд дээр 34 хүртэл хувь байгаа. Тэгэхээр энэ байдлаар ойлгоод бид нар бас нөгөө 34 дээр яг таны хэлсэнчлэн Оюу толгой дээр бид нар 34 хувь эзэмшээд, баахан 34 хувьдаа ноогдох хэмжээний мөнгийг өгөх байдлаар нөгөө хөрөнгө оруулагчтайгаа хамтарч өгөөд, тэрнийхээ хүү дээр л одоо ингээд баларчхаад явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тохиолдолд ч гэсэн 34 хувь дээр бол үнэ төлбөргүй гэсэн юм байхгүй.

Жишээлбэл эхлээд гэрээ хийгдээд л 34-өөрөө явлаа гэхэд бид нар 125 сая доллар төлөөд эхлэхээр явж байгаа асуудал учраас бид бүхэн энэ давуу эрхийн хувьцааны 10 хувьдаа бол ямар нэгэн төлбөр төлөхгүйгээр ингээд явах юм гэдгийг, явах байдлаар гэрээнд явж байгаа. Мэдээж сүүлийн бүх ашигуудыг Монголын талын авах ашигийг бол Үндсэн хуулийн 6.2-т бол найдвартай хүрэхээр гэрээндээ бол заалт оруулж, энэ зарчмаар гэрээ хийгдэж байгаа гэдгийг хэлье. Юуны засаглалын хувь дээр бол Бадрах-Энерджи компани, Орано компани 66, Мон-Атом компани 34 хувийн хувьцаа эзэмшээд явж байгаа одоогийн байдлаар. Мэдээж энэ талын ил тод байдал гэдэг дээр бол бид бас онцгой анхаарч ажиглана гэдгийг танд хэлье.

**Р.Сэддорж:** 6 номерын микрофоныг өгье.

**Д.Цолмон:** Мөнхсоёл гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. ЗГХЭГ Цолмон. Энэ 5.4 дэх хэсэг бол ерөнхийдөө одоо Цөмийн энергийн тухай хууль дээр 5.2 болон 5.3-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээ бол үнэ төлбөргүй шууд эзэмшиж байгаа. Үүнээс илүү хувиар буюу 34-өөс илүү эсвэл 50-аас илүү хувиар эзэмших төрийн шийдвэр гарсан тохиолдолд энэ асуудлыг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хувь хэмжээнээсээ

хамаараад нэмж хувьцаа эзэмших боломжийг нь олгосон ийм заалт байгаа.

Бидний оруулж ирсэн энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр бол 5.4 дээр бол ерөнхийдөө энэ хувь хэмжээг өөрөөр тогтоож болно буюу доошоо, дээшээ хязгааргүй байхаар, гол нь л энэ өөрөө Монгол Улсын энэ төслөөс хүртэх үр өгөөж нь эдийн засгийн хувьд ашигтай байх энэ зохицуулалтыг л хангах ёстой, энэ хувилбаруудыг нь санал болгож байгаа юм. Яг энэ Сэддорж гишүүний энэ саналын томъёолол дээр биччихсэн байгаагаар 5.2, 5.3-д зааснаас илүү хувиар төр хувьцаа эзэмших тохиолдолд энэ хувилбаруудыг ашиглана гэдэг энэ томъёолол бол яг энэ хуулийн төслийн үзэл баримтлалаас бол аягүй өөр болоод эхэлчхэж байгаа гэсэн үг. Тийм.

Ер нь бол бүтээгдэхүүн хуваах юм уу, Амнатаар орлуулж байгаа тохиолдолд төрийн эзэмшлийн хувьцаа угаасаа л буурна. Яагаад гэхээр бид нар өөр арга хэлбэрээр тэндээ нөгөө ашигтай байх хувилбараа сонгож, үр өгөөжөө хүртэх гээд байгаа гэсэн үг. 5.4-өө бид нар одоо байгаа хуулийн төслөө үлдээж бол болно. Өөрөөр хэлбэл илүү хувиар буюу хувьцаагаа хувьцаа эзэмшлээ нэмэгдүүлж байгаа тохиолдолд хөрөнгө оруулах гээд байгаа тохиолдолд тэр нь эдийн засгийн хувьд ашигтай байх ийм тооцоолол гарч байгаа бол тэр заалтаа бид нар үлдээгээд, зөвхөн энэ хувь хэмжээгээ бууруулах буюу өөр хувилбаруудаар ингэж орлуулж буюу хослуулан хэрэглэж болох энэ заалтаа тусад нь 5.5 дахь заалт болгож бол тусгаарлаж бол болно гэсэн үг. Тийм.

**Р.Сэддорж:** Тодруулга байгаа юу? Энэний дараа, би шууд уншаад л тэгээд л болно шүү дээ. Одоо асуух юм уу? Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** 5.4 дээр энд нэг үг байна л даа. Эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан гээд. Тэгэхээр өөрөөр хэлбэл эдийн засгийн хувилбар

гэдэг чинь энэ санхүүгийн тооцооллоос хамаараад жишээлбэл санхүүгийн тооцоо хийдэг хүмүүс бол мэдэж байгаа. Өгөөжийн хувь ганц хувьсагч өөрчлөөд л бүх юм өөр болдог. Тэгэхээр энэ ЗГ-ын эзэмших хувийг өөрчлөх асуудал энэ эдийн засгийн тооцооллоос хамаарч байна л даа. Тэгэхээр өөрөөр хэлбэл өгөөжийн хувь. Би зүгээр жишээ авч үзэхэд 20 жилийн дараах сая төгрөг, сая доллар бол өнөөдрийн үнэ цэнээр өгөөжийн 5 хувиар тооцоход сая доллар биш өнөөдөр энэ 376 мянган доллар байна. Тэгэхээр энэ эдийн засгийн өгөөж тооцоходоо та бүхэн өгөөжийн хувиар ямар хувиар тооцож байгаа вэ? Тэрний үндэслэл юу вэ? Тэрийг асуумаар байна. Тэгээд дараа нь тодруулъя.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер.

**Г.Намчинсүрэн:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө бол цацраг идэвхт ашигт малтмал бол Цөмийн энергийн хуульд зааснаар хэмжээнээс үл хамаараад стратегийн ач холбогдолтой ордод иүүд хамаарчхаж байгаа. Тэгээд стратегийн ач холбогдолтой орд дээр төрийн эзэмшлийн хувьд бол одоогийн байгаа эрх зүйн орчинд бол яригдах ёстой. Мөн дээрээс нь хөрөнгө оруулалтын гэрээний асуудал бол яригдах ёстой. Тэгэхээр бид нар сая Туваан сайд ч хэлж байна, Цолмон дарга ч бас хэллээ. Үндсэндээ Үндсэн хуулийн 6.2-т заасан дийлэнх өгөөжийг нь Монголын ард түмэнд ноогдох хувилбарыг л авч үзье гэж байгаа юм.

**Р.Сэддорж:** Тодруулга, тодорхой хариулах хэрэгтэй байгаа. Сая хариулсангүй дээ, хэн хариулах юм бэ? 9 номер. Асуултад их тодорхой хариулаарай.

**А.Алтанхундага:** Өгөөжөө 10 хувиар тооцсон байгаа. 10 хувиар бууруулж жил болгон тооцоод явсан.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Тэгэхээр энэ хувь чинь өөрөө маш субъектив учраас энэ дээр илүү тодорхой болгох хэрэгтэй байгаа. Жишээлбэл 10 хувь. Би түрүүн хэлсэн шүү дээ. 5 хувиар тооцоход discount rate-г 5 хувиар тооцоход 20 жилийн дараах сая доллар чинь өнөөдөр 370 мянган доллар л байгаа гэж байна. Тэгэхээр 10 хувь гэхээр нэлээн өндөр discount-тай тооцсон юм байна. Тэгэхээр яг энэний би түрүүн асуусан. Яагаад 10 хувь гэж, үндэслэл нь юу юм бэ, хувь нь юу юм бэ, үндэслэл нь юу юм бэ гэж асуусан, үндэслэлийг нь хэлж өгөөч?

**Р.Сэддорж:** Хариулт 9 номер уу?

**А.Алтанхундага:** Үндэслэл дээр бид хэд янз бүрийн хувилбар тооцож үзсэн л дээ. Жишээлбэл 6 хувийг. 6 хувь төсөл бол 47 жилийн туршид хэрэгжинэ нөхөн сэргээлттэйгээ. Тэгээд 6 хувийг тооцохоор их эрсдэлтэй болоод байсан. Тэгээд ер нь хөрөнгө оруулагчтай тохиролцсоны үндсэн дээр ер нь 10 хувиар тооцоод байгаа л даа одоогийн төсөл дээр.

**Р.Сэддорж:** Хариулт хангалтгүй гэж үзэж, 1 минут Энхтүвшин гишүүнд өгье.

**Д.Энхтүвшин:** Тэгэхээр сая хэлсэн би үгэндээ энэ ЗГ-ын эзэмших хувийг өөрчлөх асуудал чинь санхүүгийн тооцооллын энэ discount rate-г яаж тооцохоос хамаарч, ашигтай, ашиггүй байх эсэхийг шийдэж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ бүх юм чинь үнэ цэн тооцоход наад 10 хувь байх уу, хэдэн хувь байх вэ гэдгийг энэнээс хамаарч бүх юм өөрчлөгдөж байна. Тэгэхээр ийм заалтыг жишээлбэл ингээд нээж өгч байгаа нь бол энэ зөвхөн төсөл биш бусад төслүүд дээр ч гэсэн энэ өгөөжийн хувийн discount rate-г яаж авахаас хамаараад засгийн төрийн мэдэлд байх

хувийг ингээд өөрчлөх ийм магадлалтай болчихож байна. Тэгээд наад үндэслэлүүд чинь зүгээр хөрөнгө оруулагч талтай ярьсан чинь 10 хувь нь илүү ашигтай бусад хувь нь ашиггүй байсан гээд ингээд өөрчилнө гэдэг чинь өөрөө их субъектив байгаа учраас энэ дээр анхаарахгүй бол наадах чинь бас их том асуудал болохоор байна шүү.

**Р.Сэддорж:** Санал гэж ойлголоо. Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** Монгол Улсын хэмжээнд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын хэд, ашиглалтын хэдэн тусгай зөвшөөрөл хүчинтэй байгаа вэ? Ямар, ямар компаниудад дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад олгогдсон байгаа вэ 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал нь би түрүүнээс хойш хөндөж яриад байгаа. Хэрвээ Багануурын ордыг тэгээд хэсэг бүлэглэлд алдчихсан бол яах вэ? Өнөөдөр нүүрсний үнэ, тэгээд энэ Улаанбаатар хотын Тэц 3, 4-ийг хангаж байгаа энэ нүүрсний хангалт ямар түвшинд байх байсан бэ 1?

2 дугаарт нь Эрдэнэтийн орд, Эрдэнэт үйлдвэрийг бас бүлэглэлд алдчихсан бол яах байсан бэ?

3 дугаарт нь Таван толгойн ордыг тухайн үедээ худалдчихсан бол юу болох байсан бэ? Тэгэхээр энэ зүйл дээр ер нь манай Уул уурхайн яам ямар байр суурьтай байдаг юм бэ? ЗГХЭГ Бас ямар байр суурьтай байдаг юм бэ? Миний хувьд орон нутгаас сонгогдсон, зүүн бүсээс сонгогдсон гишүүн, аймгийн Засаг даргаар нэлээд хугацаанд ажилласан. Тэгэхээр харамсаж явдаг зүйл бол энэ хүний гараар бүтээгдээгүй эцэг өвгөдөөс үлдээсэн ирээдүй үеэсээ зээлж ашиглаж байгаа энэ ордыг эзэмших гэдэг асуудал бол том асуудал шүү. Маш том асуудал. Энэ бол хэн нэг хүний гараар бүтээгдээгүй.

Тийм учраас дэлхийн зах зээл дээр энэ түүхий эдийн үнэ цаашид улам л өснө. Энэ яагаад гэвэл шавхагддаг баялаг. Тийм учраас энийг захиран зарцуулах, эндээ эзэн байх, баялагтаа эзэн байна гэдэг энэ асуудлууд Монголчуудын хувьд бол цаашид хамгийн хурцаар тавигдана. Өөрөөр хэлбэл бид баялгаа зөв удирдаж чадахгүй бол, зөв шийдвэр гаргаж чадахгүй бол Латин Америкийн, Африкийн зарим орнууд шиг нөхцөл байдалд орно. Байгалийн баялаг зөндөө их байдаг, энийгээ зөв удирдаж чадахгүй бол хүнд байдалд орно. Энийг би яагаад ярьж байна гэхээр орон нутгийн удирдлагаар ажиллаж байсан учраас энэний чинь зовлон бэрхшээлийг мэднэ. Энийг баялагтаа эзэн байхад уул уурхайг зөв эргэлтэд оруулахад Монголчууд эзэн байхад үр хүүхэд, ахмад үе, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хувийн хэвшил энэний үр шимээр сайхан амьдардаг байхад хувь нэмрээ оруулах зорилгоор энэ Улсын Их Хуралд сонгогдсон. Сонгогчид маань энийг дэмжсэн гэж би бол хувьдаа бодож байгаа.

Тийм учраас энэ асуудал дээр онцгой анхаарахгүй бол болохгүй. Тэгээд хэдэн орд байгаа юм бэ? Энэ ордуудыг цаашаа ингээд би түрүүн хэллээ, Багануур, Эрдэнэт тэгээд эдгээр юм шиг ингээд шилжүүлээд, шийдээд ингээд явчихвал яах вэ? Тийм учраас энэ дээр ер нь Их Хурал шийдэх нь зөв гэж үздэг юм уу, зөвшөөрөх нь зөв гэж үздэг юм уу, ЗГ өөрөө олгох нь зөв гэж үздэг юм уу? Эсвэл Ашигт малтмалын газар Кадастрын хэлтэс өнөөгийн зохицуулалтаар шууд олгоод явах нь зөв гэж үздэг юм уу гэдгийг л би сонирхож мэргэжлийн яамнаас асууж байгаа юм. Яг энэ нь бол ингээд протоколд үлдэнэ.

**Р.Сэддорж:** Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Бадамсүрэн гишүүнтэй асуудлууд дээр бол адилхан Монгол Улсын иргэний хувиар, эцэг хүний хувиар, өрхийн түргэний хувиар яг

адилхан санаа зовж байгаа. Тэгээд энэ дээр нэг зүйлийг хэлэхэд, манайхан тэр лиценз энэ тэрийг тодорхой тоог нь бэлдэж байгаарай. Энэ мэдээж энэ Багануурын ордыг би мэдэж байна. Шивээ-Овоо дээр ч билүү ингээд тойроод лицензүүдийг нь авчихсан. Нөгөө төрийн уурхайнууд нь тодорхой мэдээлэлгүй ч юм уу, болно доо гэж бодож байгаад алдсан асуудлыг бол ЗГ-ын хуралдаанаар оруулж лицензийг нь цуцалж, тухайн ордуудад нь, тухайн уурхайнуудад нь үлдээж байсан асуудлыг бол ярьж байх шиг байна. Тэгэхээр энэ дээр бол мэдээж нийтийн олонхын эрх ашигийг, эрх ашиг нь аль талдаа байна тэр талд нь шийдээд явах нь бол мэдээж зөв.

Яг энэ байгалийн баялаг дээр бол би нэг тоо хэлчихье. Саяхан Австралид очоод ирсэн. Тэгэхэд Австрали улсад нийт газар нутгийнхаа Австрали бол өөрөө тив улс, 32 хувийг хайгуулын лиценз байдлаар өгчихсөн байгаа. Канад улс гэхэд хайгуулаа 100 хувь хийгээд дууссан байгаа. Тэгэхээр тухайн улс орны хувьд бол газрын доорх баялгаа хэдий хэмжээний, ямар баялаг, хаана байгаа вэ гэдгээ мэдэх нь бол маш чухал асуудал. Тэгэхээр манай Монгол орны хувьд бол өнөөдөр газар нутгийн 3,2 хувь хайгуулын 1000 лицензтэй ингээд байж байгаа улс. Тэгэхээр харьцуулалт дээр бол бид нар гайгүй л яваа юм байна лээ.

Ер нь бол бас ингээд гадаадын улс орнуудыг ингээд харьцуулахаар бид бүхэн ДНБ-ээрээ хэд байгаа билээ тийм ээ, одоо нэг дөнгөн данган 6000 доллартой л явж байгаа байх. Тэгэхээр ямар ч байсан эхний ээлжид энэ улс орны хөгжил бид нар гарааны ижил нөхцөлөөс гарсан улсуудаасаа аль хэзээ хоцорчихсон. Муулаад байдаг улсуудаасаа бүүр тээр хойно хоцорчихсон байгаа асуудлууд байна. Тэгэхээр эхний ээлжид бид нарт өвөг дээдсээс өгсөн энэ байгалийн баялгаа хариуцлагатайгаар, зүй зохистойгоор орон нутгийн иргэд болон улсын төсөвтөө ашигтай байдлаар ашиглаж, нэг хүнд ноогдох ДНБ-ээ 10000

ам.доллар давуулж авах гэдэг асуудал бол бид нар эрх ашигийн эрэмбээрээ бол эхний асуудал байх шиг байгаа юм.

Тэгэхээр асуудал дээр бол нэг яг энэ өнцгөөс нь хандаад бид нар энэ чинь хэрвээ энэ улсын иргэдийн өмч юм бол төрийн нийтийн өмч юм бол энийгээ бас энэ Баялгийн сангийн тухай хууль баталсантай холбогдуулаад эндээ мөнгө оруулах талд нь ашиглаад явах нь зөв гэсэн ийм байр суурьтай байгаа. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа одоогоор зогссон байгаа. Тэгээд энэ асуудлыг ЗГ дээр яг агентлаг, яаман дээрээ биш бүүр газар олголтыг эцсийн байдлаар ЗГ дээр шийдэж байгаа шиг ЗГ дээр эцэслэн шийдэх гэдэг байдлаар хууль, эрх зүйг өөрчлөх тал дээр бэлтгэл ажлыг хангаад явж байгаа гэдэг хариулт хэлье. Манайхан нэмээдэхье.

**Р.Сэддорж:** 3 номер.

**Г.Намчинсүрэн:** Бадамсүрэн гишүүний асуултад нэмж хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Энэ цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг бол ЗГ шийдвэрлээд явж байгаа одоогийн зохицуулалтаараа. Бусад төрлийн ашигт малтмалыг бол солбилцлыг нь батлуулаад ашигт малтмал таны хэлдэг шиг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастр, кадастрын хэлтсүүд шийдээд явдаг. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн асуудлыг бодлогыг нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр оруулах, тусгай зөвшөөрөл олгох харилцааг бол ЗГ шийдвэрлэх бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн гарсан тийм зарлигтай байдаг. Тэгэхээр энэ асуудал дээр та бол санаа зоволтгүй байх. Энэ ЗГ-ын хэм хэмжээн дээр байгаа асуудал юм гээд 1 дүгээрт хэлмээр байна.

2 дугаарт та энэ тусгай зөвшөөрөл асууж байна. Одоогийн

байдлаар хайгуулын 3 цацраг идэвхт ашигт малтмалын, ашиглалтын 8 зөвшөөрөл байгаа. Энийг болбол нэг ашиглалтын бол 4 компани эзэмшиж байгаа, хайгуулын бол 1 компани тусгай зөвшөөрөл эзэмшээд явж байгаа.

**Р.Сэддорж:** 8 номер.

**Д.Сугарсүрэн:** Сугарсүрэн Мон-Атом компанийн Захиргаа, удирдлагын албаны дарга. Бадамсүрэн гишүүний асуултад тодруулж хариулъя. Түрүүн тэр тусгай зөвшөөрөл нэг мэдэхэд өөр хүн дээр шилжсэн байдаг, түрүүн тэр шилжилтийн асуудал дээр Бадамсүрэн гишүүн санаа зовоод байх шиг байна л даа. Энэ юун дээр цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгоход бол өөр энгийн тусгай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохоос бол өөрөө онцлогтой. Энэ дээр хуучнаар бол мэргэжлийн хяналтын байгууллага, тагнуулын байгууллага, Цөмийн энергийн комиссоос тусгай хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо санал авдаг. Тэгээд 2015 оны Ерөнхийлөгчийн 15 оны 77 дугаар зарлиг гэж байгаа. Тэрүүгээр нь газрын ховор, цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой асуудлын бодлогын асуудлуудыг шийдвэрлэхдээ заавал ЗГ-ын хуралдаанаар оруулж, шийдвэрлэж байхыг төрийн холбогдох байгууллагууд үүрэг өгсөн. Тэгээд Аюулгүй байдлын зөвлөлөөр зөвлөмж гаргуулдаг. Ингэж байж асуудал шийднэ. Тэрнээс биш ямар нэгэн ашигт малтмалын юм уу, кадастр юм уу хэлтсийн дарга шийдвэр гаргаад явах ийм боломж байхгүй.

Нөгөө талаар тусгай зөвшөөрөл шилжүүлэхтэй холбоотойгоор бол Цөмийн энергийн тухай хуулиар тусгай зөвшөөрлийг, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг худалдах, барьцаалах, бэлэглэх болон өөр бусад хэлбэрээр бусдын эзэмшил ашиглалтад шилжүүлэхийг хориглоно гэсэн бүүр заалттай. Өөр бас нөгөөдөх

нь тухайн компанийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 5 дээр, 5-аас илүү хувьцаа нэмж гаргах юм уу эсвэл бусдад шилжүүлэхдээ бол Цөмийн энергийн комиссоор оруулж, шийдвэрлэж байдаг. Түүнээс биш нөгөө бусад юу шиг, тусгай, энгийн тусгай зөвшөөрөл шиг хувьцаагаа бол өөр нэгэн байгууллагад худалдах, барьцаалах тийм байдлаар шилжүүлэх тийм боломжгүй. Үүгээрээ бол илүү онцлогтой тийм харилцаа байгаа шүү гэдгийг нэмж хэлэх гэсэн юм.

**Р.Сэддорж:** Тодруулга  
Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** Цөмийн энергийн тухай хуулийн 11.2.1.1 дээр ингэж байгаа юм. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх гээд цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох гээд. Тэгээд ер нь яах вэ би энэ дээр бол яг зөв бодолтой байсан юм байна даа гэдэгтээ бол маш их баярлаж байна. Яагаад гэвэл Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Ерөнхийлөгчийн зарлиг гарсныг бид нар мэдэхгүй. Бүгдийг бид мэдэхгүй шүү дээ. Зөвхөн одоо байгаа бид нарт тараагдсан хуулийн нэмэлт, өөрчлөлт болон хуулийн хүрээнд би асуултаа асууж, зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг хуульчлах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. ЗГ-ын шийдвэр л гарах ёстой энэ дээр. Би хэлээд байгаа шүү дээ тэртээ тэргүй өндөр барилга барихад ЗГ зөвшөөрөл өгдөг, согтууруулах ундааны үйлдвэрт зөвшөөрөл өгдөг байж энэ цацраг идэвхт бодисын зөвшөөрөл өгөх асуудлыг ЗГ өөрөө шийдье.

Тийм учраас энэ зарчмын зөрүүтэй санал хураалгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ бол өөрөө онцгой асуудал. Тэгээд тийм учраас та бүхэн энийг энэ хууль дээр өөрчлөлт оруулахад бол дэмжих юм байна гэж ойлголоо. Зөв үү? Одоогийн явж байгаа

зохицуулалтаар, тэгээд энэ дээр би хариултаа авъя гэж бодож байна. Туваан сайд бол санал нэг байна гэсэн. Мэргэжлийн байгууллагууд, Цөмийн энергийн комисс ямар саналтай байдаг юм бэ? Ийм Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Ерөнхийлөгчийн зарлиг гээд явж байгааг хуульчлаад Их Хурал бүрэн эрхээрээ тогтооё гэдэг дээр санал нэг байгаа юм байна гэж ойлгож болох уу гэдгийг би хариулт авъя.

**Р.Сэддорж:** Хариулт Туваан сайд.

**Ц.Туваан:** Бадамсүрэн гишүүнтэй зарчмын хувьд санал нэг байгаа. Тэгээд энэ өөрөө онцгой, цацраг идэвхт асуудал бол тусгай хуулиар зохицуулагддаг онцгой асуудал учраас энэний лиценз олгох, ашиглах, шилжүүлэхтэй холбоотой асуудлыг нэлээн өндөр түвшинд ярья гэдэг асуудлыг бол дэмжиж байгаа. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Ерөнхийлөгчийн зарлигийг бол яг зөв. Түүн дээр бол та бас яг хууль дээр байгаа мэдээллийнхээ хүрээнд асуудал тавьсныг бол ойлгож байна. Энэ бол тэр бусад зөвлөмж юмнууд нь бол байгаа. Одоо энэ асуудлыг Засгийн газар дээр шийдээд явж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг манай ажлын хэсэг нэмж тодорхой зүйл, заалтаар нь уншиж өгнө үү.

**Р.Сэддорж:** 3 номер Намчинсүрэн.

**Г.Намчинсүрэн:** Бадамсүрэн гишүүний асуултад нэмж хариулъя. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 77 дугаар зарлигаар цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийг ашиглах талаарх төрийн бодлогыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг ЗГ-ын хуралдаанаар шийдвэрлэж байх зарлиг гарсан байдаг. Тэгэхээр энэ хүрээндээ 2015 оноос хойш энэ хайгуулын болон ашиглалтын тусгай

зөвшөөрөл олгох асуудлаар дандаа ЗГ шийдвэр гаргаад явсан байдаг.

Жишээ нь одоо ч гэсэн манай дээр Гурвансайхан компанийн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг бол олгох асуудал бас яригдаж байгаа. Энийг мөн адил түрүүн бас Мон-Атомаас тайлбар өгсөн 3 байгууллагын саналыг нь аваад, АМГТГ-аас манайд ирүүлээд, манайх ЗГ-аар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам авч ороод тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг нь шийдвэрлүүлнэ.

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Надад 2 асуулт л байгаа юм л даа. Нэг нь болохоороо яг ер нь Оюу толгойн гэрээн дээр гарсан хамгийн том одоо хүртэл хэл ам дагуулсаар байгаа зүйл нь буцаад л нөгөө Үндсэн хуулийн 6.2-ын хэрэгжилт. Тэгэхээр Монголын талд дийлэнх өгөөж нь буюу 50 дээр нэмэх нь 1 оногдох энэ тал дээр. Тэгэхээр энэ нөгөө гэрээ дээр тусаагүй учраас Оюу толгой тусдаа тооцоолол хийгээд, Монголын ЗГ тусдаа тооцоолол хийгээд энэ хэзээ ч нийлдэггүй. Тэгэхээр дараагийн 30 жилдээ ч нийлэхгүй байгаа. Тэгэхээр энийг сая Наранцогт захирал сая халти дурдах шиг боллоо. Гэхдээ тэрийг нэг баталгаажуулаад асуучих гээд байна. Энийгээ бид нар 2 талаас сууж байгаад тэр гэрээ дээрээ Монголын талын өгөөжийг яг юуг ямар, ямар зүйлүүдээр оруулж тооцох юм бэ, Францын талаасаа юуг яаж тооцох юм бэ, тэрийгээ буцаад дүгнэдэг болоод явчих юм бол дараагийн магадгүй 30 жилийн хэрүүлээсээ бид нар хамгаалж чадна гэж хараад байна л даа. Тэгэхээр бид нар хуулиудаасаа хамгийн юуны түрүүнд бол Үндсэн хуулиа хэрэгжүүлэх ёстой. Тэгэхээр Үндсэн хуулийн асуудал бол тэгээд л байнга сөхөгдөнө шүү дээ. 1 дүгээрт. Энэ тэгэхээр гэрээний нэг хэсэг болж орохоор ярилцсан уу гэдэг сая нэг асуулт нь.



2 дугаарт болохоороо ер нь гишүүдийн ингээд асуултуудыг сонсоод байхад ч гэсэн аягүй олон зарчмын асуудал яригдаад байгаа юм л даа. Нөгөө хөрөнгө оруулалтын гэрээ ярихаар. Бид нар яг энэ Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр мэдээж хууль дотор орох тийм заалтууд байна. Зарчмын зүйлүүд гэрээ дээр тусахад хэцүү шүү дээ. Ер нь тусах боломжгүй тийм ээ. Тэгээд ер нь урд талыг нь ингээд томоохон Оюу толгой, Тавантолгойн гэрээнүүдийг яаж явсныг нь судлаад үзэхээр жишээлбэл Оюу толгойн гэрээ 2009 оны 10 сарын 6-нд зурагдсан байдаг юм. Тэгээд 2008 оны 12 сард тухайн үедээ яг ЗГ, Улсын Их Хурал руу чиглэл аваад, Улсын Их Хурлын тогтоолоор Оюу толгойн болон Тавантолгойн гэрээг хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үндсэн зарчим, удирдамжаа Улсын Их Хурлын тогтоолоор авсан байдаг байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр нөгөө гэрээ дээр тусахгүй гол зарчмууд, энэ гишүүдийн хэлээд байгаа эд нар бол үндсэн зарчмууд бол Улсын Их Хурлын тогтоолоор гарах нь зөв л гэж бодоод байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр сая ЗГ оруулж ирэхдээ бол Цөмийн энергийн тухайн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирээд байна л даа. Тэгэхээр энэ дээр тусахгүй зарчмууд дээр гишүүдийн ихэнх асуултууд яваад байгаа байхгүй юу. Бид нар шууд хөрөнгө оруулалтын гэрээ рүү нэг их орохгүй. Гэхдээ үндсэн зарчмаа л анхнаасаа тохироод явчихвал аль, аль талдаа ойлгомжтой юм болов уу л гэж бодоод байгаа юм л даа. Тэгэхээр Оюу толгойг аваад үзсэн ч гэсэн энэ Улсын Их Хурлын тухайн үедээ бол 40 дүгээр тогтоол гэж гарч ирж байсан.

Тэгэхээр яг Оюу толгойн гэрээ болон Тавантолгойн гэрээ байгуулахад ЗГ-ын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим гэж байгаа шүү, зарчим болон удирдамж гээд Улсын Их Хурлын тогтоолоор авч байсан

байхгүй юу. Тэгэхээр энийг та бүхэн бодож үзсэн үү? Энийг ер та бүхэн ЗГ, тэгээд Туваан сайд, мөн ЗГХЭГ, Наранцогт захирал та нар энийг яг юу гэж бодож байгаа юм бол? Энэ шаардлагатай гэж үзэж байгаа юу? Тэгэхгүй бол яг гишүүдийн асуулт бол дийлэнх нь л зарчим хөндөгдөөд байна л даа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Хэн хариулах вэ? Эхлээд Туваан сайд, дараа нь Наранцогт дарга.

**Ц.Туваан:** Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 2019 онд Улсын Их Хурлаар батлагдсан. Энэ хууль дотор энэ Баялгийн сангийн хуулийг баталж, энэ уул уурхайн баялгаас олох орлогыг Баялгийн санд мөн энэ доторх байгаа сангуудад төвлөрүүлж, эндээсээ ард иргэддээ хуваарилах замаар хүртээнэ гэдэг энэ концепцын дагуу л асуудлууд явж байгаа. Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээн дээр бол бид нар Монгол Улс алдсан гэж үздэг, алдсан зүйл байгаа. Тэгэхээр энийг бид нар юу гэдэг юм энэтэй яг харьцуулаад энэ дээр яаж хандсан бэ гэдэг асуудлыг бол ажлын хэсэг дээр бараг зэрэгцүүлж тавьж байгаад л ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид нар алдаа гаргахгүй талд нь л ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Энэ Монгол Улс бол өөрөө энэ олон улсад ингээд явахаар нэг тийм барьцгүй, буцдаг, нэг гэрээ байгуулчихаад энэ гэрээгээ буцаад шинэ хууль батлаад тэр хууль руугаа, хуулиа буцааж үйлчлэх маягтай ингээд оруулаад явчихдаг улс гэдэг иймэрхүү л зүйлүүд нэлээн явж байна. Энэ ганцхан Оюу толгой гэрээн дээр ч биш, Петрочайна Дачин Тамсаг компанийн бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр хүртэл ийм асуудлууд байгаад байна. Тэгэхээр одоо бол ЗГ дээр ямар байр суурь барьж байгаа гэхээр бол ЗГ яг байгаа таны энэ хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө байгаа энэ зарчмууд гээд байгаа зүйлүүдийг хуульдаа тусгаад, хөрөнгө оруулалтын

гэрээ хийсэн бол яг тэр гэрээндээ суудаг байдлаар энэ асуудалдаа хандана. Дахиж шинэ хуулийн орчин бүрдүүлээд, тэрийгээ гэрээгээ өөрчлөх тал руу нь шахаж, дараа нь янз бүрийн татварын маргаантай асуудлууд гаргаж тавьдаг энэ байдлаас сална гэдэг ийм зарчмын байр суурьтай явж байгаа. Өөрөөр хэлбэл олон улсын нэр хүнд дээр ч гэсэн энэ бол маш сөргөөр нөлөөлж байгаа гэдгийг бас хэлье.

Юун дээр Оюу толгойн гэрээн дээр бид нар энэ удаагийн Цөмийн энергийн тухай хуулийг дагаж оруулж ирж байгаа татварын хууль дээрээ тодорхой бас нэг заалт зааж байгаа нь Татварын хууль дээр байгаа 4 төрлийн татвараа л тогтворжуулах асуудлаа илүү тодотгоод, бусад асуудлыг бол Оюу толгойн гэрээ шиг ийм ерөнхий байдлаар нь ойлгоод явахгүй гэдэг зарчим дээр бол дагаж мөрдөх хууль дээр бол оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Гэрээ бол Улсын Их Хурлаар орж ирнэ. Энэ хөрөнгө оруулалтын гэрээ. Яагаад гэхээр Улсын Их Хурал өөрөө ард түмний төлөөлөл учраас энэ гэрээний зүйл, заалтуудыг бол мэдэх эрхтэй, энд оролцох эрхтэй. Тийм учраас энэ гэрээ бол хууль Их Хурлаар орж ирнэ. Дээрээс нь таны хэлсэн гэрээтэй хамт Улсын Их Хурлын тогтоолын төсөл бол орж ирнэ гэж ингэж ойлгох нь зөв байх.

**Р.Сэддорж:** 4 номер Наранцогт дарга.

**С.Наранцогт:** Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Энэ Монгол талд ноогдох үр өгөөж юу вэ гэдэг дээр бол 2 талаасаа нэлээн суусан. Валютын сан дээр бол 2 төрлөөр энэ үр өгөөж тооцох юу юуг оруулах вэ гэдэг тийм зүйл байгаа юм, 2 төрлөөр гаргаж үзсэн. Тэгээд бид нар хамгийн өргөн хүрээнд нь авч үзээд, хөрөнгө оруулагч тал бол хамгийн өргөн хүрээгээр нь энэ юу гэдэг юм агаарын бохирдлын хураамж энэ тэр гээд бүх зүйлийг

Монгол талын ашиг гэж тооцохоор бид нар бол хамгийн богино хувилбараар нь авч үзээд, зөвхөн энэ байгаль орчныг сэргээхэд орж байгаа зардал бол тэртээ тэргүй бид нарын шууд гарах зардал учраас Монгол талын өгөөж бол болохгүй гэдэг ийм байр суурь дээр ярилцаж ингэж явж байгаа. Тэгээд ойлголт бол нэг болж байгаа. Ер нь товчхондоо хэлэхэд.

2 дугаарт бол энэ нөгөө Монгол талын шууд хүртэх өгөөж энэ Үндсэн хуульд орсон тэр 6.2-ын заалтыг бол бид нар олон газраас яг энд юу гэж ойлгох вэ гэж нэлээн нарийн авч үзэж байгаа юм. Тэгээд энэ дээр бол шууд бас энэ Үндсэн хуулийн цэцээс авхуулаад ингээд шууд энийг ингэж ойлгоно гэж хариулт өгч чадахгүй юм байна лээ. Тэгэхдээ тухайн үед хэлэлцэж байгаа протокол юмнуудтай бас манай хуулийн баг энэ тэр ажиллаад, үзээд, танилцаад энэ зүйлүүдээ бол гаргаад, энийгээ бол яг 2 хөрөнгө оруулагчтайгаа бол хамт ярьж байгаа. Тэгэхээр энэний ойлголцсоны дараа бол ойлголтын зөрөө бол гарахгүй.

2 дугаарт бол нөгөө гэрээнийхээ загварыг ч гэсэн манай тал өөрсдөө өөрийн загвараа гаргаж явна гээд энэ дээр бас дотоодын хуулийн зөвлөхүүд ажиллуулж, гэрээний төслөө гаргаж ирж байгаа. Тэрүүгээрээ Оюутолгойгоос бол эрс ялгаатай гэж үзэх ёстой.

3 дугаар зарчим энэ дээр энэ Тэгшибаяр доктороос авхуулаад хөндлөнгийн экспортууд нэлээд хэмжээгээр орсон. Иргэний байгууллагаас орсон. 5 үндсэн дэд ажлын хэсэг дээр бол.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Тэгээд Оюу толгой тухайн үедээ гэрээ байгуулж байхдаа ч гэсэн 2 талаас ойлголцоод л, асуудалгүй зарчмын хувьд тохирлоо гээд байгуулж байсан байх л даа. Тэгээд

хамгийн гол нь нөгөө гэрээн дээр тусгахгүй болохоор 4 жилийн дараа, 5 жилийн дараа үнэлээд дүгнэхдээ дахиад л ондоо юм ярих байхгүй юу. Яг энэ, хэрвээ бид нар гэрээн дээрээ тусгаж чадахгүй ингээд зарчмын хувьд ерөнхийдөө тохирч байна гээд протоколдоод орхих юм бол энэ маргаан дахиад л гарч ирнэ гэсэн үг. Тэгэхээр бид нар тэрийг мэдсээр байж гэрээнийхээ хэсэгт оруулж болохгүй, оруулж чадахгүй бол энэ аягүй том эрсдэл болох гээд байна гэж харах гээд л байна л даа. Яг Оюу толгойн хэрүүл яг дахиад дараа нь Францдаа өрнөх вий.

Тэгэхээр ер нь Францын талтай ч гэсэн гэрээн дээр оруулснаараа энэ аль аль нь харилцан ашигтай. Ер нь гэрээ гэдэг чинь 2 талын эрсдэлийг хаасан л үүрэг хариуцлага шүү дээ. Тэгэхээр энийг заавал тусгаасай л гэж хэлэх гээд байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт Туваан сайд тэр хөрөнгө оруулалтын гэрээ Улсын Их Хурлаар орж ирэхэд чинь аль түрүүн Улсын Их Хурлын тогтоол шаардлагагүй болж байгаа байхгүй юу. Улсын Их Хурлын тогтоол, миний хэлэх гээд байгаа санаа Улсын Их Хурлын тогтоолоор энэ Хөрөнгө оруулалтын гэрээ 2 талаас байгуулахдаа ийм үндсэн 5 зарчмыг баримталж байгуулаарай гэсэн Улсын Их Хурлын чиглэл байхгүй юу удирдамж. Тэр удирдамжийнхаа дагуу 2 талтай хэлэлцээд, Хөрөнгө оруулалтынхаа гэрээний эцсийн хувилбараа Улсын Их Хуралд өргөн барих ёстой. Тэр үед бол нөгөө зарчмынхаа дагуу гэрээ хийгдсэн байна уу гэдэг дээр 2 талаас ярихгүй бол яг Хөрөнгө оруулалтын гэрээ энэ Улсын Их Хурлын тогтоолын үндсэн зарчим, удирдамжгүй явахаар яах вэ гэхээрээ Хөрөнгө оруулалтын гэрээ дараа нь Улсын Их Хурлаар орж ирэхэд ямар асуудал гарч ирэх вэ нөгөө гишүүд тухайн үедээ нөгөө зарчим нь тохироогүй, яг түүнтэй уялдаатай ингээд бөөн асуудлыг дагуулах вий л гэж би хараад байна л даа.

Тэгэхээр аль, аль талаасаа эрсдэлээ хаахын тулд Улсын Их Хурлаас өгч байгаа зарчим нь ч гэсэн нөгөө нэг ёсондоо хашаа л гэсэн үг шүү дээ. Яг энэ хашааны хүрээнд хэлэлцүүлээд явуулъя, ийм Үндсэн хуулийн 6.2-оо яах юм, татварын асуудлууд байна, байгаль орчны нөхөн сэргээлт гэх мэтчилэн гол асуудал дээрээ зарчмаа Улсын Их Хурлаас чиглэл тогтоолоор уг нь авчихвал аль, аль талынхаа эрсдэлийг дараа нь Хөрөнгө оруулалтын гэрээ орж ирэхэд хаана гэж хараад байгаа юм л даа.

**Р.Сэддорж:** Туваан сайд хариулах юм уу? Туваан сайд нэмж тодруулъя.

**Ц.Туваан:** Тантай 100 хувь санал нэг байна. Хөрөнгө оруулалтын гэрээн дээрээ бид нар сууж байгаад, тэгээд яг тулж байгаа асуудлуудаа шийдвэрлэх арга механизмаа тодорхой болгоод, ямар ч байсан энэ хуульдаа ийм өөрчлөлтийг оруулж байж цаашаа явах юм байна гэдэг зүйлээ оруулж ирж байгаа. ЗГ дээр бол Хөрөнгө оруулалтын гэрээг Улсын Их Хурлаар оруулна гэсэн байр суурьтай байгаа. Түүн дээрээ хэдүүлээ бүүр тал талаасаа нарийн детальний яриад, саяын таны хэлсэн байгаль орчны асуудал, хууль, эрх зүйн асуудал бүх зүйлүүдээ гэрээндээ туссан юм уу, тусаагүй юм уу гэдгийг бага ард түмний төлөөллөөр filter хийгээд, тэгээд баталсан нь зөв байх гэж ингэж бодож байгаа.

Манай дээр бол мэдээж энэ 2 дахь удаагаа хийгдэж байгаа гаднын томоохон хөрөнгө оруулалтын гэрээ. Эхний гэрээ дээр бол бид нар янз бүрийн алдаа мадагтай зүйлүүд гарсан гэж ард түмэн ч тэр, парламентын гишүүд ч тэр үзэж байгаа учраас энэ гэрээн дээр 2 дахь энэ том Хөрөнгө оруулалтын гэрээ дээр бол бид нар алдах эрх байхгүй. Тэгэхээр энэ дээр нэлээн бүх зүйлийг заах, зааж оруулах, тодорхой зааж оруулах, тусгах гэдэг энэ зүйлүүдээ бид нар бол

оруулж байгаа. Тэгэхээр гэрээ Их Хурлаар батлагдах учраас та тухайн үед нь саналуудаа хэлээд оруулаад, хяналт шалгалтаа тавиад явчхаж болох байх гэж бодож байна.

**Р.Сэддорж:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан 3 гишүүнээс зарчмын зөрүүтэй санал ирсэн, 5.4 дээр. Дэгийн тухай хуулийн 39.20 дээр төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж, санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэсэн ийм дэгийн зохицуулалттай юм байна.

Эхний санал. Миний бие энэ саналыг оруулж ирж байгаа. “5.4.Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсын эдийн засгийн үр ашигтай хувилбарыг харгалзан энэ зүйлийн 5.2, 5.3-д заасан хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно” гэснийг “энэ хуулийн 5.2, 5.3-д зааснаас илүү хувиар төр хувьцаа эзэмших тохиолдолд стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай хувилбарыг харгалзан Засгийн газрын

өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэх.

Тайлбар нь бол цацраг идэвхт ашигт малтмалын орд нь бол нөөцөөсөө үл хамааран стратегийн ордод хамаардаг. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бол төрийн эзэмшлийн хувийн хэмжээг ихэсгэх болон багасгах боломжтойгоор хийсэн, зохицуулсан байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 5.2, 5.3-д заасан төрийн эзэмшлийн хувь ганхаж болохоор байна. 34, 51-ээс доошгүй хатуу тогтоосон. Ингэж бууруулах боломжтойгоор хуулиар зохицуулах нь бол төр өөрийн эзэмшлийнхээ хувьцаагаа алдах эрсдэлтэй байна гэж болгоомжилж байгаа юм. Энэ бол миний санал.

Бадамсүрэн гишүүний санал бас яг 5.4 дээр. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулах буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ зүйлийн 5.2, 5.3-д заасан хувь хэмжээг Засгийн газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох бөгөөд Засгийн газар тусгай зөвшөөрлийг нь олгох, бусдад шилжүүлэх, шилжүүлсэн талаар хийх, танилцуулгыг хийх бүрдээ Улсын Их Хуралд танилцуулна гэсэн ийм санал байна. Бадамсүрэн гишүүн та саналаа тайлбарлаж болно энийгээ.

**М.Бадамсүрэн:** Энэ дээр нэг ийм асуудал гарчихлаа. Бид нар мэдээллээ дутуу авсан юм байна. Би түрүүн энэ төслийн нөгөө 4 дэх хэсгийн 9.10, 10 дээр санал хураалгахдаа хэрвээ саяын мэдээлэл байсан бол шууд Засгийн газрын тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх нь Засгийн газрын эрхэд байна гээд л заах байсан юм. Яагаад гэвэл бид нар энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж болон Ерөнхийлөгчийн зарлигаар явахдаа

энэ Цацраг идэвхт ашигт малтмалын тухай хуулийн зохицуулалтыг бид нар өөрчилж явж байна шүү дээ. Өөрөөр хэлбэл хуулиас давсан зохицуулалтаар явж байна гэсэн үг.

Тэгэхээр Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал хуульд нийцүүлэх ёстой байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ дээр нэгэнт энэ хуулийг хэлэлцэж байгаа юм чинь манай төсвийн, Эдийн засгийн байнгын хороо нөгөө төсвийг Их Хурал сайжруулж батлах ёстойтой адилхан бид нар энэ одоо зохицуулж байгаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжөөр зохицуулдгийг нь шууд энэ хууль дээрээ оруулаад, түрүүн санал хураадгийг өөрчлөөд, Их Хурлын зөвшөөрөл авна гэдгийг нь болиод, зөвхөн ЗГ энийгээ шийддэг одоогийн зохицуулалтыг чинь хууль болгоод энэ дээрээ оруулчих ёстой байхгүй юу.

Өөрөөр хэлбэл энэ Цөмийн энергийн тухай хуулийг өргөн мэдүүлэхдээ одоо үйлчилж байгаа энэ зохицуулалтуудыг нь хууль болгоод гаргах нь манай мэргэжлийн Байнгын хорооны хувьд бол чухал зүйл шүү дээ. Тэгээд тэнд Ерөнхийлөгчийн зарлигаар энэ хуулиас өөрөөр яваад байна шүү дээ. Тэгэхээр энийгээ тэрэнд нь нийцүүлээд зөв бодлого учраас энэ дээрээ ЗГ өөрөө хуралдаанаараа олгодог бусдад шилжүүлдэг юмыг нь хууль дээр олгоод өгөхгүй бол одоо зохицуулалтаар 11.2.1.1-д зааснаар агентлагийн асуудал яваад байгаа байхгүй юу. Агентлаг олгохоор, тийм байгаа биз хууль дээр чинь. Тэгэхээр энийг ийм горимын санал байна Байнгын хорооны даргаа. Тэгвэл энэ дээр санал хураалгах хэрэггүй би энэ 3 дахь дээрээ.

Өөрөөр хэлбэл 2 дахь саналаа дахин хураалгая. Тэгэхдээ одоогийн Ерөнхийлөгчийн зарлигт нийцүүлээд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид нийцүүлээд тэгээд Их Хурал зөвшөөрөл өгнө гэдгийг нь болиод, ЗГ хуралдаанаар

хэлэлцэн шийддэг гэвэл өнөөгийн зохицуулалтад яг ингээд нийцээд л, бид нар яг энийгээ шийдчихсэн Байнгын хороо болох байхгүй юу.

**Р.Сэддорж:** Аюулгүй байдлын байнгын хороон дээр гишүүний саналыг дахиж хураалгая. Зохион байгуулж оруулаад таны саналыг. Туваан сайд уучлаарай, байхгүй юм байна, харин байхгүй гэнэ. Санал гаргасан гишүүн л саналаа тайлбарлах ёстой гээд байна Дэгийн хуульд. 3 дахь гишүүний санал Энхтүвшин гишүүний санал. 5.4. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны, төрийн хувийг энэ юу гэж байгаа юм бэ? Өөрчилсөн буюу орлуулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад өнөөгийн үнэ цэнээр эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ хуулийн 5.2, 5.3-д заасан хувь хэмжээг Засгийн газрын газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоож болно гэсэн ийм 3 санал зарчмын зөрүүтэй санал. Энхтүвшин гишүүн саналаа тайлбарлая.

**Д.Энхтүвшин:** Түрүүн хэлсэн. 1 энэ тооцоолол эдийн засгийн үр ашигтай байх эсэх нь энэ нь өнөөгийн үнэ цэн тооцож байгаа нэг л хувьсагч discount rate-ээс энэ өгөөжийн хувиас хамаарч байгаа учраас. Тэгээд энийг тодотгож өгч энэ дээр өнөөгийн үнэ цэнээр эдийн засгийн үр ашигтай гэж оруулах саналтай байгаа юм. Яагаад вэ гэхээр эдийн засгийн үр ашигтай гэхээр яг энэ өнөөгийн үнэ цэн гэдэг асуудлыг тодорхой оруулж ирвэл ядаж энэ хүүгийн түвшний асуудлуудыг илүү тодорхой ярих юм болов уу гээд энэ утгаар нь өнөөгийн үнэ цэнээр гэдэг, эдийн засгийн үр ашигтай гэдгийг нь өнөөгийн үнэ цэнээр эдийн засгийн үр ашигтай гэж тодотгож ийм санал оруулсан байгаа.

Тэгэхээр түрүүн хэлсэн жишээлбэл 20 жилийн дараах сая доллар 5 хувиар, өгөөжийн хувийг 5 хувиар тооцоход өнөөдөр энэ 370 мянган доллар байгаа. Хэрвээ энийг 10 хувь болгочихвол энэ өнөөдөр 148 мянган доллар байгаа. Тэгэхээр ийм асар том зөрөөтэй ийм том савлагаа гарч байгаа учраас энийг тодотгож, өнөөгийн үнэ цэнээр гэдэг тодотголыг эдийн засгийн үр ашиг гэдгийг нь өнөөгийн үнэ цэнээр эдийн засгийн үр ашигтай байх ёстой гэдгийг тодотгож оруулах ийм санал байгаа. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье.

**Р.Сэддорж:** Тэгээд энэ сая Дэгийн тухай хуулиар эхний ирсэн саналаар нь санал хураалт явуулъя. Миний тайлбар бол өөрөөр тогтоож болно гэсэн тодорхойгүй юмыг л 34, 51 байна гэсэн ингэж, доошгүй байна гэсэн ийм томъёоллоор оруулж байгаа юм. Санал хураалт. 27,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Бадамсүрэн гишүүний саналаар санал хураалт явуулъя. Саналаа тайлбарлачих юм уу дахиад? Тэгье.

**М.Бадамсүрэн:** Одоогийн зохицуулалтыг холбогдох яам тайлбарласан учраас энийг яг одоогийн зохицуулалтыг нь энэ өргөн мэдүүлж байгаа нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өөрчлөлт оруулаад тэгээд би энэ нөгөө зарчмын зөрүүтэй санал дээрээ бага зэрэг өөрчлөлт оруулаад ингэж найруулах саналтай байна. 5.4 дээр энэ хуулийн 5.2.5.3-д зааснаас илүү хувиар төр хувьцаа эзэмших тохиолдолд уг хувийг төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоож болох ба гээд тэгээд шинэ томъёоллоо оруулж байгаа. Мөн цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг шинээр олгох, бусдад шилжүүлэх асуудлаар Засгийн газрын хуралдааны тогтоолоор хэлэлцэн шийдвэрлэсэн

талаар танилцуулгыг жил бүр Их Хуралд танилцуулж байна гээд.

Өөрөөр хэлбэл Их Хурал энэ дээр зөвшөөрөл өгөхгүй, зүгээр ЗГ ер нь яаж шийдсэнийгээ жил болгоны эцэст Их Хуралд ер нь танилцуулж бай гээд. Тэгэхдээ цаашидаа бол ер нь одоо Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Ерөнхийлөгчийн зарлигийг энэ хуульдаа өөрчлөлт оруулж нэг болгох хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ хооронд чинь зөрчил үүсээд байна шүү дээ. Цөмийн энергийн тухай хууль буюу Их Хурлын баталсан хууль дээр Ашигт малтмалын газар олгоно гэхихсэн байхад тийм үү, одоо бол ЗГ ингэж хуралдаанаар шийдвэрлэж явж байна шүү дээ. Тэгэхээр энийг яах вэ нэг болгочихвол нэг л Монгол Улсын төр юм чинь энийг тодорхой болгочихвол уг нь амар байхгүй юу. Тэгээд би энэ утгаар л ер нь зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм.

Яагаад гэвэл би бол санаа зовоод байсан юм. Цаашидаа энэ уран, цацраг идэвхт ашигт малтмалыг олгох, бусдад шилжүүлэх асуудлаар ямар нэгэн сөрөг ноцтой үр дагаврууд гарах вий. Тийм учраас Монголын ард түмний төлөөлөл парламент энэ дээр зөв шийдвэр гаргаасай гэж бодож л энэ зарчмын зөрүүтэй саналыг би гаргасан. Тэгэхдээ одоо энэ зохицуулалтад нь нийцүүлээд, олонх гишүүд Их Хурал заавал энэ дээр зөвшөөрөл өгөөд яах юм бэ гэдэг асуудлыг тавьж байгаа бол ингэж бас өөрчлөн найруулж санал хурааж өгч, дэмжиж өгөөч гэж Байнгын хорооны гишүүдээс хүсэж байна.

**Р.Сэддорж:** Санал хураалт 38,9 хувиар санал дэмжигдсэнгүй. Энхтүвшин гишүүний санал санал хураалт. 66.7 хувиар санал дэмжигдлээ. Энхтүвшин гишүүний төхөөрөмж ажиллаагүй байна энийг протоколд тэмдэглүүлье. Санал хураалт явуулж дууслаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. Бямбасүрэн гишүүн үү? Бямбасүрэн гишүүнээр тасаллаа. Бямбасүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ш.Бямбасүрэн:** Энэ хууль дээр болохоор бид нар яах вэ эдийн засгийн юмнуудыг нь ихэвчлэн оруулж ирсэн байна. Тэгэхдээ энэ Монгол Улсад ер нь анх удаа бид нар энэ ураныг олборлох гэж байгаа юм. Тэгээд технологи тал дээр нь бид нар аягүй дутуу энэ хууль дээр оруулж ирсэн байна гэж харж байгаа юм. Одоо энэ ингээд ажлын хэсгийнхэн бол газрын доор уусган олборлохоор ашиглана. Энэ нь хамгийн эдийн засгийн үр өгөөжтэй, байгаль орчинд сөрөг нөлөө багатай гээд байгаа юм. Тэгээд энэ хууль дээр орж ирж байгаа нь болохоор дандаа цацрагийн хамгааллын хөтөлбөр, цацрагийн хамгаалал гээд байгаа юм.

Гэтэл яг энэ нэг газрын доор уусган баяжуулах, уусган олборлох технологи нь өөрөө бас хүчил ашигладаг. Тэгээд тэр хүчил нь өөрөө бас нөгөө нэг газрын доорх усыг бохирдуулдаг, эргээд тэр усыг нөхөн сэргээх боломжгүй гэдэг шалтгаанаар олон улсад бас энэ уран олборлолт дээр ингээд ер нь маш их эсэргүүцэлтэй тулгардаг юм байна. Тэгээд энийг аягүй дутуу тусгасан байна. Тэгээд энэ дээр ер нь яаж оруулах ёстой юм бэ? Бас энэ нэг ажлын хэсгийнхнээс бас асуумаар байна.

**Р.Сэддорж:** 5 номерын микрофон Тэгшбаяр.

**Н.Тэгшбаяр:** Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя. Тэр уран байгаа орчин чинь тэр цацрагтай, бас химийн хувьд хоруу чанартай ийм элемент тэр орчны усыг бол бохирдуулна гэж ойлгохоос илүү зүгээр ус ашигласны төлбөр ч юм уу ярьж болно. Түүнээс биш урантай газрын ус угаасаа цацрагтай,

урантай тэр байгаа орчных нь орчин нь бол техникийн орчин байгаа учраас түүн дээр сүү хийсэн ч, ус хийсэн ч, хүхрийн хүчил хийсэн ч техник орчин байх юм 1 дүгээрт.

2 дугаарт бол энэ нөхөн сэргээлтийн тухайд бид нар анх ямар РН орчинтой байсан тэр орчинд нь аваачих тухай л яриа байдаг. Түүнээс биш угаасаа тийм ундны усыг бохирдуулж байгаатай адилхан ойлгож ерөөсөө болохгүй гишүүнээ. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Бямбасүрэн гишүүн тодруулъя.

**Ш.Бямбасүрэн:** Ингээд мэргэжлийн хүмүүс бид нар ингээд энэ талаар нэлээн сайн судалгаа шинжилгээний юмнуудыг харах ёстой юм. Ингээд аман байдлаар энэ доороо тэртээ тэргүй гүний усандаа хортой ингээж ярьж болохгүй байх. Яагаад гэхээр энэ газрын доор уусган олборлох гэдэг технологи нь өөрөө 2, 3 янзаар ашиглаж байгаа юм байна. Нэг нь хүчил ашиглаж байна, нэг нь болохоор шүлтлэг уусмал ашиглаж байна. Гэтэл Америкт бол яг энэ хүчлийг нь ашиглахыг нь ингээд ер нь бараг зогсоочоод байна. Яагаад гэхээр газар луу оруулж байгаа тэр хүчлээ өөрсдөө контролоо алдчихаад байна, бүрэн буцаагаад ингээд авч чадахгүй байна гэдэг үндэслэлээр.

Тэгэхээр аль хэдийн уран байгаа газар дээр нь ахиад нэмж хүчил хийгээд байгаа учраас тэр нь илүү хортой байна гэж байна. Гэтэл шүлтлэг уусмалыг одоо ашиглаж байна. Энэ нь өөрөө эргээд харьцангуй бага сөрөг нөлөөлөлтэй байна гэж үзээд ашиглаж байгаа байхгүй юу. Тэгээд тэд нар ингээд зүгээр ингээд, тэртээ тэргүй доор тэр ураны юутай байгаа юм чинь бид нар дээр нь ингээд ямар ч хамаагүй юм хийчхэж болно гэсэн хандлагаар хандахгүй байна л даа олон улсад. Тэгэхээр энийг бид нар аягүй зөв

тайлбарлах хэрэгтэй болчихоод байна. Бид нар мэдээлэлгүй байгаад байна л даа.

**Р.Сэддорж:** Хэн хариулах юм бэ? 5 номер.

**Н.Тэгшбаяр:** Бямбасүрэн гишүүний асуултад нэмж тодруулга өгье. Тэр геологийн нөхцөлөөсөө шалтгаалаад ямар арга хэрэглэх вэ гэдэг нь тодорхойлогдож байгаа. Дэлхий дээр бол өнөөдөр бол газар доор уусган баяжуулах аргаар 51-ээс 60 орчим хувь нь ингээж ашиглаж байгаа. Таны хэлж байгаагаар бол урьд нь Монгол Улс уран олборлож байгаагүй биш, ОХУ хуучин бол Зөвлөлт гэж байхад бид нар хамтраад уран олборлоод Дорнодоор гаргаж ирсэн жишээ бол байгаа. Тийм учраас тэр гидрогеологийнх нь нөхцөлөөс шалтгаалаад ямар технологи ашиглах вэ гэдгээ л сонгож байгаа ийм л зүйл байгаа.

Тэр сая нөгөө усны тухайд бол тийм бохирдуулж байна гэхээс илүү тэр ус ашигласны төлбөрийн тухай яриа болохоос биш тэр угаасаа дэлхий үүсэхэд тэнд уран байж байсан. Тэнд энэ газар доор нь цацрагийн тийм сөрөг нөлөөтэй газрууд нөлөөтэй, дээрээс нь химийн хувьд хоруу чанартай ийм элемент. Энийг олборлоогүй байсан ч газар доор нь тийм техникийн орчин байна л гэж хэлэхийг хүсэж байна. Тэр нөгөө жишээлбэл тэр сая хэлсэн Америк, Канад энэ тэрд бол тэр нөгөө геологийн нөхцөл нь өөр учраас тэнд таарсан технологийн сонголт нь л өөр байгаа. Түүнээс биш бид нар уран олборлох юу гэдэг юм хүхрийн хүчил олборлохгүй гээд байгаа юм бол бас биш юм байгаа юм гишүүнээ.

**Р.Сэддорж:** Хариулт хангалтгүй гэж үзсэн учраас 1 минут Бямбасүрэн гишүүн.

**Ш.Бямбасүрэн:** Монгол Улсад өмнө нь яг шар нунтгийг бол баяжуулж олборлосон юм бол байхгүй. Зүгээр хүдэр хэлбэрээр нь экспортолсон тийм

туришлага бол байгаа. Тэгэхээр бид нар энэ шар нунтгийн талаар ярьж байгаа шүү. Тэгээд одоо энэ ер нь та ингээд сайхан амаараа л ингээд л тайлбарлаад байна л даа. Уг нь бол энийг чинь яг ингээд газар луу шингээсэн тэр хүчлээ бид нар контролдож чадахгүй байна, бүрэн хэмжээнд буцаагаад гаргаж авч чадахгүй байгаа учраас энэ нь илүү хоруу байна. Шүлтлэг уусмал нь илүү хор нөлөө нь багатай учраас ядаж үүгээр нь ашиглая гээд тэмдэглэчихсэн байгаа байхгүй юу. Тэрнээс биш тэр геологийн бүтцээр биш. Тэртээ тэргүй геологийн бүтэц чинь газрын доор уусган баяжуулах чинь геологийн нөхцөл нь бүрдсэн тохиолдолд энэ технологийг ашиглаж байгаа юм. Энэ технологийг ашиглахдаа ямар уусмал ашиглах вэ гэдгийг нь л яриад байгаа байхгүй юу. Манай дээр чинь болохоор энэ хүчлийг ашиглана гэсэн орж.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Бямбасүрэн гишүүний санаа зовж байгааг бол ойлгож байна. Тэгээд бид бүхэн бас хүчил, шүлт гэдэг дээр нэмэлт мэдээлэл боловсруулаад танд танилцуулъя. Би бас өөрөө шүүд энэ мэргэжлийн хүн биш. Тэгэхдээ ер нь бол энэ ураны энэ яг агуулчихсан энэ нөөц бол өөрөө 2 талаараа шаварлаг нөгөө ус нэвтрэхгүйгээр ийм орчинд ингээд битүү орчинд байгаа. Тэгээд энд нь бол хүхрийн хүчилтэй маш сул хүчилтэй уусмалыг шахаж өгч, энийг өөрт нь шингээж гаргаж ирж ашиглах л ийм технологи.

Бид нар бол энгийн түвшинд гэртээ наар бөглөрчихвөл ингээд содтой уусмалаар ингээд гүйлгээд угаагаад цэвэрлэдэг, машин дээр хүртэл бид нар нэг машины моторыг цэвэрлэхдээ хүртэл нэмэлт шингэн хийгээд тодорхой хэмжээнд асааж байгаад буцааж аваад ашигладаг гэдэг шиг бусад тал руугаа бол энэ ашигласан хүхрийн хүчил агуулсан энэ ус маань өөрөө тархах энэ



асуудал нь бол нэлээн баталгаатай.  
Өөрөөр хэлбэл.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Туваан сайдын тайлбарыг яалаа. Бадамсүрэн гишүүний хувьд түрүүний саналыг бол Аюулгүй байдлын байнгын хороон дээр хүргүүлнэ. Туваан сайд сая өөрөө амлалаа. Үзэл баримтлалын зөрөөтэй юмнууд орж ирсэн учраас гэж та бас нөлөөллөө. Тийм учраас өөрийнхөө амласнаар Ашигт малтмалын тухай хууль дээрээ энэ ойлгомжгүй энэ юмнуудыг бас та маань яахгүй бол энэ тухайн үед тохиролцож байгаад яана гэсэн энэ заалтаас болж Монгол Улсын эрх ашиг л яаж магадгүй, маш аюултай. Энэ 34, хувь процент гэдэг бол хамгийн чухал. Энийг бас хэлье. Ашигт малтмалын хуулийн ажлын хэсэг ажиллаж байгаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналууд ирээгүй байна.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Асуулт асуух гишүүд алга байна. Гишүүд асуулт, хариулт авч дууслаа. 5 дугаар зүйлтэй холбогдуулан, 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал 1 ирсэн боловч Бадамсүрэн гишүүний энэ санал бол Дэгийн тухай хуулиараа бол хөндөгдөөгүй, энэ хууль дээр оруулж ирээгүй заалтыг та оруулж ирсэн байна. Тийм учраас энэ удаа бол хураалгах боломжгүй юм байна. Ажлын хэсэг бол энэ орж ирээгүй заалт байна, одоо хуульдаа байж байгаа заалт юм байна. Ингээд зарчмын зөрүүтэй санал 5 дугаар зүйл дээр байхгүй байна.

Хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулт байна уу, гишүүд байна уу? Дагасан 2

хууль байгаа. Байхгүй байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Хамт өргөн мэдүүлсэн 2 дугаар хууль Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Компанийн тухай хууль дээр. Кнопоо дар, Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

**Д.Энхтүвшин:** Би бас өмнө нь нөгөө эхний хэлэлцэх эсэх дээр бас асууж байсан. Энгийн хувьцааг ер нь шууд давуу эрхийн хувьцаа руу шилжүүлдэггүй, улсуудын хуулиуд ч гэсэн тийм байдаг. Тэгэхээр энэ онцгой нөхцөлд ингээд шилжүүлэхээр бий болж байна. Тэгэхээр зөвхөн энэ хуулийг биш би нөгөө бусад хуулиудад юу болчих вий энэ компанийн тухай, тийм жишиг болчих вий. Өөрөөр хэлбэл өрийн хариуцлагаасаа зугтаагаад компаниуд ямар нэгэн байдлаар хуульд өөрчлөлт энд тэнд нь оруулаад энгийн хувьцааныхаа үүргээсээ зугтаагаад, жишээлбэл давуу эрх рүү болгочих вий.

Энэ хуульд энэ Цөмийн энергийн тухай хуультай хамааралгүй, зүгээр энэ компанийн өөрийнх нь энэ хууль зохицуулалттай харилцаа дээр энэ сөргөөр нөлөөлөх юм гарчхаж магадгүй гэж тийм болгоомжлол байгаад байгаа юм. Тэгэхээр энэ тусгайлан, хуульд тусгайлан зааснаас бусад гэхээр жишээлбэл энэ дээр заавал Улсын Их Хурлаар орж байж л энэ асуудал ярилцаж байж, шийдэгдэж байж л гарна гэсэн ойлголт байх шиг байна. Тэгэхээр энэ дээр яах вэ саяын хэлдэг шиг ийм асуудлууд гэнэт нууцаар ч юм уу эсвэл энд тэндхийн хуульд дагалдаж орж ирээд ч юм уу энэ компанийн үндсэн хариуцлага хүлээх ёстой энэ хүмүүс нь ингээд хариуцлагаасаа зугтаагаад давуу эрхийн болгох ийм эрсдэлүүд гарах боломжууд байж болох уу, үгүй юу? Энэ

талаар зүгээр хуулийн хүн байвал энэ талаар хариулж өгөөч.

**Р.Сэддорж:** Хариулт 6 номер, Солонгоо дарга, Цолмон.

**Д.Цолмон:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ-ын Цолмон. Тэр давуу эрхийн хувьцаатай холбоотой зохицуулалт яг яах вэ Компанийн хууль дээр энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж болохгүй гэдэг заалт байгаа. Тэрийг бид нар хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд гэдэг ийм өөрчлөлтийг оруулж ирж байгаа. Энэ яах вэ мэдээж төөрөгдөл бусад хуулиудад тийм энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаагаар сольж болох ийм зохицуулалт орж болбол түүгээр явна гэдэг л ийм өөрчлөлт байгаа юм. Тэгэхээр гишүүний саналаар бол Цөмийн энергийн тухай хуульд зааснаас гээд тухайлан хуулийнхаа зохицуулалтыг заагаад, хязгаарыг нь хязгаарлуулж бол болно.

Давуу эрхийн хувьцаанд хөрвүүлснээр энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг яг шууд эдлэхгүй байх ийм зохицуулалт гэж бол ойлгож бас болохгүй байгаа юм. Компанийн тухай хууль дээр энэ давуу эрхийн хувьцаанд эзэмшигчийн эрх, үүргийг ер нь компанийнхаа дүрэмдээ илүү тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн хооронд энэ орон зайг нээлттэй үлдээсэн байгаа. Тэгэхээр энэ дээр бидний эхний яриа хэлэлцээрийн явцад эхний шатад хөрөнгө оруулагч талтай тохироцсон зүйл бол энэ ноогдох давуу эрхийн хувьцаанд ноогдох энэ онцгой эрхүүдийг бол дагалдуулж бол олгож байгаа тийм ээ, хориг тавих, түүнчлэн ТУЗ-д гишүүнээ томилж, асуудлууд дээр төлөөлөн оролцуулах, саналын эрхтэй байх гэх мэтчилэн өөрөөр хэлбэл компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хараат бус гишүүдийн байдаг энэ хороодыг бас гишүүнээ оролцуулах гэх мэтчилэн иймэрхүү зохицуулалтыг

бол Хөрөнгө оруулалтын гэрээнийхээ явцад бид нар тохируулж болно.

Хөрөнгө оруулалтын гэрээтэй хамтдаа хувьцаа эзэмшигчдийн хооронд бол хувь нийлүүлэгчдийн гэрээ гэдэг ийм хувийн эрх зүйн гэрээ хийгдэнэ. Энэ дээр бол илүү нарийвчилж энэ компанийн дүрэм дээр тусгах энэ ноогдол давуу эрхтэй холбоотой, давуу эрхийн хувьцаатай холбоотой ноогдол ашигийн бодлого, түүнчлэн давуу эрхийн эзэмшигчийн эрх, хуралд яаж оролцох вэ, хувьцаа эзэмшигчийн хувьд ямар асуудлууд дээр нь оролцох вэ гэдгийг бол дүрмээр бүүр чөлөөтэй тохирох ийм бололцоотой гэж харж, хэлэлцээгээ бол хийж байгаа. Өөр чинь гайгүй тийм ээ.

**Р.Сэддорж:** Хассуурийн, тодруулга байна уу? Энхтүвшин гишүүн тодруулга.

**Д.Энхтүвшин:** Би энэ дээр, Цолмонд баярлалаа. Тэгээд энэ дээр зарчмын зөрүүтэй саналаа одоо илэрхийлчхэж болох уу? Энэ хуульд заасан гэж нийтээр ингэж нээхийн оронд энгийн гэснийг Цөмийн энергийн тухай хуульд зааснаас бусад тохиолдолд гэж ингэж засах ийм зарчмын зөрүүтэй санал гаргахыг хүсэж байна. Дэмжиж өгөхийг хүсье.

**Р.Сэддорж:** Ганхуяг гишүүнийг асуултаа асуусны дараа. Ганхуяг гишүүнд үг өгье.

**Х.Ганхуяг:** Энэ тогтворжуулах татварын орчин гээд энэ элэгдэл хорогдол тооцох хугацаа, гарсан алдагдлыг ирээдүй рүү шилжүүлэн тооцох хугацаа гээд энэ хөнгөлөлт хийх болсон шалтгаан нь юу юм бэ 1 дүгээр асуулт?

2 дугаар асуулт болохоор энэ Хөрөнгө оруулалтын хууль нөгөө тогтворжуулалтын гэрээний асуудлыг бас энэ тогтворжуулалтын татварын орчинтойгоо уялдуулж явна гэж байгаа

юм байна л даа. Тэгээд энэ 1 дүгээр асуулт дээрээ хариултыг нь авчхаад дахиад тодруулъя.

**Р.Сэддорж:** Хариулт Туваан сайд.

**Ц.Туваан:** Энэ Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой тогтворжуулалтын асуудлууд орж ирж байгаа. Тэгээд энэ дагалдах хуулиар энэ Татварын хуульд өөрчлөлт оруулах орж ирж байгаа. Тэгээд энэ дээр энэ Татварын хуульд заасан тэр татваруудыг л тогтворжуулна. Өмнө нь Оюу толгой дээр гараад нэлээн тийм өргөн байдлаар ойлгогчихсон энэ асуудлыг биш, тодорхой татварын хууль дахь асуудлуудыг тогтворжуулах гэсэн ийм логигоор явж байгаа.

**Р.Сэддорж:** Ганхуяг гишүүн тодруулга.

**Х.Ганхуяг:** Энэ ирээдүй рүү шилжүүлэн тооцох хугацаа гэдгээ яг юу гэж ойлгох вэ? Тэгээд элэгдэл хорогдлыг гэж байгаа юм, энэ уул уурхай дээр бол ер нь ихэнх оронд татварын ямар нэг хөнгөлөлт байдаггүй л дээ. Тэгээд энэ элэгдэл хорогдлыг нь яг яаж тооцох гээд байгаа юм бэ? Зөвхөн боловсруулах шат дээр нь л хөнгөлөлт өгдөг. Татварын тогтворжуулалт эд нар хийдэг л дээ ер нь бол зарчим. Гэрээ дээр та нар тогтворжуулах гэж байгаа юм байна гэж ойлголоо. Гэхдээ элэгдэл хорогдол тооцох хугацаа эд нараа яаж, ямар өөрчлөлт оруулах гээд энэ зүйл, заалтыг оруулсан юм бэ? Тэгээд ирээдүй рүү шилжүүлэн тооцох хугацаа гэдэг яагаад ийм зүйл, заалт оруулсан юм бэ? Би энэ дээр яг тодорхой хариулт авмаар байна.

**Р.Сэддорж:** 6 номер.

**Д.Цолмон:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ Цолмон. Энэ Цөмийн энергийн хуулийн төслийг дагаад бол 2 хууль дээр өөрчлөлт орсон. Татварын ерөнхий хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хууль байгаа. Тэгэхээр

ерөнхийдөө бол энэ Цөмийн энергийн тухай хуульд бол хөрөнгө оруулалтын гэрээний зохицуулалт тусгайлан үйлчилж явж байгаа. Өөрөөр хэлбэл Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээний зохицуулалтаас тусад нь өөрийнхөө хуулиараа хөрөнгө оруулалтын гэрээний эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн ийм хууль байгаад байгаа.

Тэгэхээр энэ Цөмийн энергийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын ерөнхий хууль гэсэн энэ 3 хуулийн хүрээнд энэ татварын тогтвортой орчны асуудал хөндөгдөж яригдаж байгаа. Гэтэл өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хүрээнд энэ 3 хууль 3-лаа зөрчилтэй. Өөрөөр хэлбэл суурь хууль буюу Татварын ерөнхий хууль дээр юу гэж заасан байдаг вэ гэхээр энэ татварын хувь хэмжээг л тогтворжуулах асуудал дурдагдсан байдаг хувь хэмжээ. Гэтэл Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр юу гэж заасан байдаг вэ гэхээр татварын орчныг тогтворжуулах буюу татварын хувь хэмжээ дээр нэмээд тэр татварын хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын иж бүрдлийг хэлнэ гээд заачихсан. Өөрөөр хэлбэл бүх эрх зүйн зохицуулалтыг нь тогтворжуулахаар ийм зохицуулалт бол Хөрөнгө оруулалтын тухай хуульд байгаад ингээд 2 хоорондын хуулийн зөрчил үүсээд байгаа учраас, би тайлбарлаж байна эргүүлээд. Тэгэхээр энэ дээр бол, энэ асуудлыг бол яах вэ манай ажлын хэсэгт Сангийн яамны Тэлмүүн дарга байгаа, Татварын бодлогын газрын дарга илүү тодруулж тайлбарлах байх.

Өмнө нь бас бид нар хөрөнгө оруулалтын гэрээг Оюу толгойтой хийсэн төслийн хүрээнд бол татварын орчныг бүхэлд нь тогтворжуулснаас болж энэ олон улсын гэрээ хүртэл, давхар татварын гэрээ хүртэл тогтворжиж байгаа асуудал байгаа. Тэгэхээр энэ татварын суурийг багасгах,

энэ үнэ шилжилтийн асуудалтай холбоотой олон улсын гэрээгээр хүлээсэн Монгол Улсын хүлээх үүргийг бид нар тогтворжуулахгүй юм. Тийм учраас зөвхөн энэ татварын хувь хэмжээг тогтооход ашиглагддаг элэгдэл хорогдол, алдагдал шилжүүлэх асуудлыг л тогтворжуулъя. Энэ бол өөрөөр хэлбэл яалт ч үгүй тэр хувь хэмжээг тогтооход оролцдог ийм бүрэлдэхүүн хэсэг байгаа. Түүнээс биш.../минут дуусах/

**Р.Сэддорж:** Хариулт хангалтгүй байна гэж үзэж байна. Нэмж хариулах уу? 6 номер нэмж хариулъя.

**Д.Цолмон:** Энэ асуудлыг илүү Сангийн яамны Татварын бодлогын газар, давхар бас хурал давхцаад орж ирээгүй байгаад байна. Ер нь бол ажлын хэсгийн хүрээнд ярьж байх явцад бол яг энэ элэгдэл хорогдол алданги шилжүүлэх асуудал хамгийн их хөндөгддөг. Татварын хувь хэмжээг. Тийм учраас үүгээр хязгаарлая л гэсэн санаа.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүн саналаа. 1 санал хураалттай. Ингээд сая тэр холбогдох хүмүүсийг нь гишүүний асуултад бичгээр юм уу, яаралтай холбогдуулж хариулт авах өгөөрэй.

Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшинээс 1 дүгээр зүйл дээр Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийн “энгийн” гэснийг “Цөмийн энергийн тухай хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд энгийн” гэж өөрчлөх гэсэн ийм саналтай байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. Саналаа тайлбарлачихсан тийм ээ, тайлбарласан. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Энхтүвшин гишүүн төхөөрөмж нь ажиллаагүй учраас зөвшөөрснөөр протоколд тэмдэглүүлж байна. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт

өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулна. Өнөөдөр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чухал хэлэлцүүлгийг хийлээ.

Энэ дээр ард түмний хамгийн гол зүйл энэ уурхай ажиллавал байгаль орчин, ард иргэдэд шууд хортой гэсэн ийм мэдээллүүд яваад байдаг. Тэгээд энэ ураны энэ асуудлаа та бүхэн энэ Мон-Атом компани, бусад Уул уурхайн яам, бусад газрууд энэ ард түмний энэ болгоомжлол, энэ юунд л маш тодорхой хариулт өгөхгүй бол маш буруу ойлголтууд яваад байгаа учраас энэ цаашидаа энэ хууль хэрэгжихэд энэ ард түмэнд ойлголтыг зөвөөр өгөхөд, өгөх асуудал бол аягүй чухал юм. Ийм учраас энэ дээрээ анхаарахыг хүсье.

12.41 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

